



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2022 оны 09 дүгээр сарын 14
№ 36 (1234)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠭᠢᠨ ᠠᠯᠪᠠᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

640.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 96	2549
641.	Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 97	2549
642.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 100	2550
643.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 101	2550
644.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 102	2551
645.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 103	2551
646.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 104	2552
647.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 105	2552
648.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 106	2553
649.	Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай	Дугаар 107	2553

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

650.	Журам батлах тухай	Дугаар 196	2554
------	--------------------	------------	------

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

651.	Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тайлбарлах тухай	Дугаар 07	2594
------	--	-----------	------

652.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсгийг тайлбарлах тухай	Дугаар 09	2598
------	---	-----------	------

653.	Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар	Дугаар 11	2600
------	--	-----------	------

654.	Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтын албан ёсны тайлбар	Дугаар 13	2607
------	---	-----------	------

تائیکس

نورتنف محضەر مر کخسرناخسرکی کدر دایخیر

300000	کمتنن 09	بهرهکن کدر بهقوهر مهمکنک بکر تخیویریه بهسن	• 0090
300000	کمتنن 09	بهرهکن کدر بهقوهر مهمکنک بکر تخیویریه بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 606	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
600000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
600000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090
000000	کمتنن 006	بایخەر بهلنگەر ن لاربهقهر بهکسفر . بهسنتنن بهتیدیسهق بهسن	• 0090

نورتنف محضەر مر دایسەر مر تائیکسن مر بهسکننک

بایخەر بهکسفر بهسن

کمتنن 006

000000



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 96

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2 дахь хэсгийн 40.2.9 дэх заалт, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 92 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаарт хүрсэн Лхам-Янжингийн Оюуныг Баянгол дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 05 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 97

Улаанбаатар
хот

Шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг, 47 дугаар зүйлийн 47.6 дахь хэсэг, Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 106 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Хуульд заасан өндөр насны тэтгэвэрт гарах эрх үүсэж, өөрөө хүсэлтээ гаргасан Ядамсүрэнгийн Алтаннавчийг Хэнтий аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 06 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 100

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Монакогийн Хант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Авирмэдийн Баттөрийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Монакогийн Хант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Уламбаярын Нямхүүг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 06 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 101

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Испанийн Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Авирмэдийн Баттөрийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Испанийн Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Уламбаярын Нямхүүг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 06 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 102

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Гүрж Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лувсангийн Баттулгыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Гүрж Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доржийн Баярхүүг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 06 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 103

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Тажикистан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Лувсангийн Баттулгыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Тажикистан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Доржийн Баярхүүг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 06 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 104

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Малайз Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Төмөрхүлэгийн Төгсбилгүүнийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Малайз Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Амарсанаагийн Төмөрийг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 06 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 105

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Филиппин Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Төмөрийн Лхагвадоржийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Филиппин Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Сосорбарамын Энхбаярыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 06 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 106

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Кипр Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Дашжамцын Батсайханыг эгүүлэн татаж, Монгол Улсаас Бүгд Найрамдах Кипр Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Лхагвасүрэнгийн Саянааг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2022 оны 06 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 107

Улаанбаатар
хот

Элчин сайдыг эгүүлэн татах, тохоон томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсаас Йорданы Хашимитын Хаант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Чулууны Баярмөнхийг эгүүлэн татаж, Монгол Улсаас Йорданы Хаант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Энхтүвшингийн Булганыг томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**УХНААГИЙН
ХҮРЭЛСҮХ**



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2022 оны 5 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 196

Улаанбаатар
хот

Журам батлах тухай

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.10, 18.17-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, урьд нь байгуулсан үндсэн болон дэмжих системээр дамжуулан үйлчилгээ үзүүлэх гэрээг шинэчлэн байгуулах арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 220 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

**ЦАХИМ ХӨГЖИЛ,
ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ҮҮРЭГ ХАРИУЦАГЧ**

Л.ЭНХ-АМГАЛАН

Засгийн газрын 2022 оны
196 дугаар тогтоолын хавсралт

ҮНДСЭН СИСТЕМИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ, СИСТЕМ АШИГЛАЖ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ, МЭДЭЭЛЭЛ СОЛИЛЦОХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь суурь болон төрөлжсөн мэдээллийн сангаас үндсэн болон дэмжих системд мэдээлэл нийлүүлэх, үндсэн болон дэмжих системээр дамжуулан төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд үйлчилгээ авах, хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх замаар мэдээлэл солилцохтой холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Үндсэн систем нь “Үндэсний дата төв” УТҮГ (цаашид “Дата төв” гэх)-д байрших тархмал бүтэц бүхий төрийн мэдээлэл солилцооны “ХУР” систем байна.

1.3. Энэ журамд заасан дэмжих систем нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.5.1-д заасан танилт, нэвтрэлтийн систем, 18.5.3-т заасан албан бичиг солилцооны дундын систем, 18.5.5-д заасан мэдэгдэл хүргэх систем, 18.5.6-д заасан төрийн үйлчилгээний нэгдсэн систем байна.

1.4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.5.4-т заасан мэдээлэл солилцооны бүртгэлийн систем нь үндсэн системээр илгээсэн, хүлээн авсан мэдээллийг илгээсэн, хүлээн авсан хугацаа, илгээгч, хүлээн авагч, мэдээллийн агуулгыг илэрхийлсэн дахин давтагдашгүй утга болон бусад мэдээллийг гэрээ байгуулахгүйгээр тухай бүр бүртгэнэ.

1.5. “И-Монгол академи” УТҮГ (цаашид “Академи” гэх) нь үндсэн болон дэмжих системийн хөгжүүлэлт, хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллана.

Хоёр.Төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд үйлчилгээ авах талаар хүсэлт гаргах

2.1. Төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд (цаашид “хүн, хуулийн этгээд” гэх) нь суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн үндсэн болон дэмжих системээр дамжуулан үйлчилгээ авах хүсэлтийг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага (цаашид “яам” гэх)-д цаасан, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

2.2. Энэ журмын 2.1-д заасан хүсэлтэд дараах мэдээллийг тусгана:

2.2.1. хүсэлт гаргагч хүний овог, нэр, иргэний бүртгэлийн дугаар, эсхүл регистрийн дугаар, хуулийн этгээдийн нэр, регистрийн дугаар, хаяг, холбоо барих мэдээлэл;

2.2.2. хүсэлт гаргагч хүн, хуулийн этгээдийн холболт хийж үйлчилгээ авахыг хүссэн үндсэн болон дэмжих системийн нэр;

2.2.3. хүсэлт гаргагч хүн, хуулийн этгээд үндсэн болон дэмжих системийг ашиглах зориулалт.

Гурав.Хүн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авах, шийдвэрлэх, хариу өгөх

3.1.Яам нь хүн, хуулийн этгээдийн хүсэлтийг хүлээн авч, энэ журмын 3.3 дахь хэсэг болон дор дурдсан шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгасны үндсэн дээр ажлын 10 өдөрт багтаан хариуг хүргүүлнэ:

3.1.1.хүн, хуулийн этгээдийн холболт хийж авахыг хүссэн үйлчилгээ нь Академийн хариуцаж байгаа цахим хуудас (developer.хур.gov.mn)-д байрших “ХУР” системээс үзүүлэх боломжтой үйлчилгээний жагсаалтад багтсан байх;

3.1.2.системд холбоход тавигдах техникийн нөхцөл, шаардлагыг хангасан байх.

3.2.Энэ журмын 3.1.2-т заасан техникийн нөхцөл, шаардлагад аюулгүй байдлын шаардлагыг тусгана.

3.3.Яам нь энэ журмын 3.1-д заасан хугацаанд Дата төв, Академиас системд холболт хийхэд шаардлагатай техникийн нөхцөл, шаардлагыг хангасан эсэх талаар дүгнэлт авна.

3.4.Энэ журмын 3.1-д заасны дагуу хүн, хуулийн этгээдэд хүргүүлэх хариу нь дараах хэлбэртэй байна:

3.4.1.хүсэлтийг хүлээн авч гэрээг байгуулах талаар хариу мэдэгдэх;

3.4.2.хүсэлтийг үндэслэл бүхий тайлбарын хамт буцаах.

3.5.Энэ журмын 3.4-т заасан хүсэлтийн хариуг цаасан, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ.

Дөрөв.Хүн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулах

4.1.Энэ журмын 3.4.1-д заасны дагуу гэрээ байгуулах тухай мэдэгдлийг хүлээн авсан хүсэлт гаргагч нь ажлын 5 өдөрт багтаан энэ журмын хавсралтаар баталсан загвар гэрээний төсөлд гарын үсэг зурж, яаманд ирүүлнэ.

4.2.Энэ журмын 4.1-д заасан гэрээний төслийг цахимаар ирүүлэх тохиолдолд тоон гарын үсгээр баталгаажуулж ирүүлнэ.



4.3. Яам нь гэрээний төслийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдөрт багтаан гарын үсэг зурж баталгаажуулан, хүсэлт гаргагчид хувийг хүргүүлнэ.

4.4. Яам нь энэ журмын 4.3-т заасан гэрээний хуулбарыг Дата төв, Академи болон Тагнуулын байгууллагад хүргүүлнэ.

4.5. Яам нь гэрээний бүртгэлийн санг хөтөлж, хадгалалт хамгаалалтыг хариуцаж ажиллана.

4.6. Гэрээний хугацаа 3 жил байх бөгөөд гэрээг цуцлах талаар хүн, хуулийн этгээдээс хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар нэг удаа сунгана.

4.7. Хүн, хуулийн этгээдийн гэрээний төлбөрийг Дата төв, Академи энэ журмын 6 дугаар хавсралтаар баталсан зардал тооцох аргачлалын дагуу тооцох бөгөөд яам хяналт тавина.

4.8. Төрийн байгууллага болон хуульд заасны дагуу гэрээний үндсэн дээр төрийн тодорхой чиг үүргийг гүйцэтгэж байгаа этгээдийн үндсэн систем болон албан бичиг солилцооны дундын систем, төрийн үйлчилгээний нэгдсэн системээр дамжуулан авах үйлчилгээ нь үнэ төлбөргүй байна.

4.9. Яам нь энэ журмын 5.1.5, 6.1.3-т заасны дагуу гэрээ цуцлах талаар Дата төв, Академиас ирүүлсэн саналыг хүлээн авч ажлын 3 өдөрт багтаан шийдвэрлэнэ.

Тав. Гэрээний хэрэгжилтийг хангах талаар Дата төвийн эрх, үүрэг

5.1. Дата төв нь гэрээний хэрэгжилтийг хангах талаар дараах эрх, үүрэгтэй:

5.1.1. энэ журмын 4.3-т заасны дагуу гэрээний хувийг хүн, хуулийн этгээдэд хүргүүлснээс хойш ажлын 5 өдөрт багтаан үндсэн болон дэмжих системд үйлчилгээний холболтыг хийх;

5.1.2. үндсэн болон дэмжих системийн түүхчилсэн бүртгэлийг хөтөлж, түүнд хяналт тавих;

5.1.3. гэрээ байгуулсан хүн, хуулийн этгээдэд гэрээнд заасан үүргээ биелүүлэх талаар шаардлага тавих, гарсан зөрчлийг арилгуулах;



5.1.4.үндсэн болон дэмжих систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалтын улмаас түр зогсолт хийх бол ажлын 3 өдрийн өмнө, гэмтэл, саатал гарсан тохиолдолд гэрээ байгуулсан хүн, хуулийн этгээдэд даруй мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

5.1.5.гэрээ байгуулсан хүн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн, холбогдсон сүлжээгээр дамжуулан халдлагын шинжтэй үйлдэл хийсэн бол холболтыг зогсоож, гэрээг цуцлах саналыг яаманд хүргүүлэх;

5.1.6.үйлчилгээний хандалт болон төлбөрийн мэдээлэл шалгах нөхцөлийг бүрдүүлэх.

5.2.Хүн, хуулийн этгээдээс шалтгаалан энэ журмын 5.1.1-д заасан хугацаа өнгөрсөн тохиолдолд уг хугацааг дахин ажлын 5 өдрөөр сунгаж болно.

5.3.Үндсэн болон дэмжих системд холбогдсон суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээллийн үнэн зөвийг Дата төв хариуцахгүй.

5.4.Дата төв нь гэрээ байгуулсан хүн, хуулийн этгээдээс энэ журмын 5.1-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой гаргасан гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.

Зургаа.Гэрээний хэрэгжилтийг хангах талаар Академийн эрх, үүрэг

6.1.Академи нь гэрээний хэрэгжилтийг хангах талаар дараах эрх, үүрэгтэй:

6.1.1.энэ журмын 4.3-т заасны дагуу гэрээний хувийг хүн, хуулийн этгээдэд хүргүүлснээс хойш ажлын 5 өдөрт багтаан үндсэн болон дэмжих системд үйлчилгээний холболтыг хийх;

6.1.2.үндсэн болон дэмжих систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалтын улмаас түр зогсолт хийх бол ажлын 3 өдрийн өмнө, системийн нэмэлт хөгжүүлэлтээс шалтгаалан сервис (API)-т өөрчлөлт орсон тохиолдолд гэрээ байгуулсан хүн, хуулийн этгээдэд даруй мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх;

6.1.3.гэрээ байгуулсан хүн, хуулийн этгээд нь техникийн нөхцөл, шаардлагыг зөрчсөн, холбогдсон сүлжээгээр дамжуулан халдлагын шинжтэй үйлдэл хийсэн бол гэрээг цуцлах саналыг яаманд хүргүүлэх;



6.1.4.мэдээлэл хариуцагчийн энэ журмын 8.1-д заасны дагуу нийлүүлсэн мэдээлэлд (API) өөрчлөлт орсон талаарх мэдэгдлийг хүлээн авч шийдвэрлэх;

6.1.5.үйлчилгээний хандалт болон төлбөрийн мэдээлэл шалгах нөхцөлийг бүрдүүлэх.

6.2.Академи нь гэрээ байгуулсан хүн, хуулийн этгээдээс энэ журмын 6.1-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой гаргасан гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.

6.3.Академи нь үндсэн болон дэмжих системээр үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг тодорхойлно.

6.4.Үндсэн болон дэмжих системд холбогдсон суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээллийн үнэн зөвийг Академи хариуцахгүй.

Долоо.Гэрээний хэрэгжилтийг хангах талаар хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

7.1.Гэрээний хэрэгжилтийг хангах талаар хүн, хуулийн этгээд нь дараах эрх, үүрэгтэй:

7.1.1.үндсэн болон дэмжих систем ашиглахад тавигдах техникийн нөхцөл, шаардлагыг хангах;

7.1.2.мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаарх дүрэм, журмыг дагаж мөрдөх;

7.1.3.цахим хэлбэрээр үзүүлсэн үйлчилгээний түүхчилсэн бүртгэлийг хөтлөх;

7.1.4.үндсэн болон дэмжих системээс авч байгаа мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу ашиглах;

7.1.5.гэрээ цуцлах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг яаманд хүргүүлэх;

7.1.6.үндсэн болон дэмжих системийг ашиглан цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх ажилтан, албан тушаалтан цахим гарын үсэг хэрэглэх;

7.1.7.хамтын ажиллагаа хариуцсан ажилтны мэдээллийг яаманд хүргүүлж, өөрчлөгдсөн тохиолдолд энэ талаар даруй мэдэгдэх;



7.1.8.системийн хөгжүүлэлтийг гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх;

7.1.9.өөрийн хариуцсан мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагааг хангаж, аюулгүй байдлыг хариуцах.

7.2.Энэ журмын 7.1.7-д заасан хамтын ажиллагаа хариуцсан ажилтан нь гэрээ хэрэгжих хугацаанд хүн, хуулийн этгээдийг төлөөлөн ажиллах эрх бүхий этгээд байна.

Найм.Мэдээлэл хариуцагчаас үндсэн системд мэдээлэл нийлүүлэх

8.1.Суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээлэл хариуцагч нь үндсэн системд мэдээлэл нийлүүлэх (API) хүсэлтийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр яаманд хүргүүлэх бөгөөд хүсэлтэд дараах мэдээллийг тусгана:

8.1.1.мэдээлэл хариуцагч байгууллагын нэр, нийлүүлэх мэдээллийн агуулга, оролт, гаралтын нөхцөл, хувьсагч;

8.1.2.энэ журмын 3.1.2-т заасан техникийн нөхцөл, шаардлагыг хангасан эсэх талаарх мэдээлэл.

8.2.Яам нь энэ журмын 8.1-д заасан мэдээлэл хариуцагчийн хүсэлтийг хүлээн авч, шалгасны үндсэн дээр ажлын 10 өдөрт багтаан хүсэлтийг хүлээн авсан эсэх талаар шийдвэрлэж, хариу мэдэгдэнэ.

8.3.Яам нь энэ журмын 8.1-д заасны дагуу хүсэлтийг шийдвэрлэхийн өмнө Дата төв, Академид хүсэлтийг хүргүүлж саналыг авна.

8.4.Яам хүсэлтийг хүлээн авсан талаар албан бичгийг Дата төв, Академид хүргүүлнэ.

8.5.Академи нь яамнаас ирүүлсэн албан бичгийн дагуу үйлчилгээ нэмэх ажлыг ажлын 10 өдөрт багтаан гүйцэтгэнэ.

8.6.Академи нь шинээр үүссэн үйлчилгээг олон нийтэд сурталчилж, өөрийн цахим хуудсанд энэ талаарх мэдээллийг байршуулна.

8.7.Мэдээлэл хариуцагч нь энэ журмын 8.1-д заасны дагуу нийлүүлсэн мэдээлэлд (API) өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 3 өдрийн өмнө Дата төв, Академид урьдчилан мэдэгдэнэ.



8.8.Суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээлэл хариуцагч нь үндсэн системээр дамжуулсан мэдээллийн түүхчилсэн бүртгэлд хандах боломжтой байна.

Ес.Гэрээний хэрэгжилтэд хяналт тавих

9.1.Дата төв болон Академи нь гэрээний хэрэгжилтийн тайланг бэлтгэн улирал бүрийн сүүлийн сарын 25-ны өдөрт багтаан яаманд хүргүүлнэ.

9.2.Яам нь тайланг хүлээн авч хэрэгжилтийг ажлын 10 өдөрт багтаан дүгнэж, шаардлагатай тохиолдолд хэрэгжилтийг сайжруулах талаар зөвлөмж, чиглэл хүргүүлнэ.

---оОо---

Журмын 1 дүгээр хавсралт

БАТЛАВ.

БАТЛАВ.

ҮНДСЭН СИСТЕМ (ХУР)-ИЙГ АШИГЛАН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

№ ...

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

Энэхүү гэрээг нэг талаас Цахим хөгжил, харилцаа холбооны яам (цаашид “яам” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр),

Нөгөө талаас _____
(цаашид “Хэрэглэгч” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)
нар (хамтад нь “Талууд” гэх) дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож гэрээг байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, “И-Монгол академи”

улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам, Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

1.2.Энэ гэрээгээр хэрэглэгчийг үндсэн системд холбож, гэрээний хавсралтад заасан мэдээллийг дамжуулах үед үүсэх харилцааг зохицуулна.

1.3.Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“Үндсэн систем” (цаашид “ХУР” гэх) гэж суурь болон төрөлжсөн мэдээллийн сангийн мэдээллийг хэрэглэгч ашиглах, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлсэн “Үндэсний дата төв” УТҮГ-т байрших төрийн мэдээлэл солилцооны системийг;

1.3.2.“Хэрэглэгч” гэж гэрээ байгуулж байгаа төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийг;

1.3.3.“Веб сервис” гэж цахим орчинд мэдээлэл солилцох боломжтой үйлчилгээг;

1.3.4.“Амжилттай дуудсан сервис” гэж тухайн сервисийг дуудаж байгаа хэрэглэгчид ашиглаж болох хариуг буцаасан байхыг;

1.3.5.“Үндэсний дата төв” УТҮГ” (цаашид “Дата төв” гэх) гэж үндсэн системд үйлчилгээний холболтыг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг;

1.3.6.“И-Монгол академи” УТҮГ” (цаашид “Академи” гэх) гэж үндсэн системийн хөгжүүлэлтийг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг.

Хоёр.Талуудын эрх, үүрэг

2.1.Яам нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

2.1.1.гэрээний хэрэгжилтийг хангах;

2.1.2.гэрээний биелэлтийг үнэлэн, гэрээний нөгөө тал болон Дата төв, Академид зөвлөмж хүргүүлэх;



2.1.3.хэрэглэгчийн ашиглаж байгаа систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалт хийх, техникийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэх, зөвлөмж хүргүүлэх;

2.1.4.“ХУР” систем, түүний сүлжээнд техникийн үзлэг, шалгалт хийхдээ хэрэглэгчид ажлын 3 өдрийн өмнө мэдэгдэх;

2.1.5.“ХУР” системийн төлөвлөгөөт шинэчлэл, сайжруулалт хийх;

2.1.6.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг гэрээний нөгөө талаас шаардах;

2.1.7.хэрэглэгчийн нэмэлт веб сервис ашиглах талаар ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэн гэрээний хавсралтад өөрчлөлт оруулах талаар гэрээний нөгөө талд мэдэгдэх;

2.1.8.“ХУР” системд гарсан аливаа доголдлыг шийдвэрлэх;

2.1.9.хамтран ажиллах явцад олж авсан аливаа мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах.

2.2.Дата төв нь энэ гэрээний 2.1.3, 2.1.4-т заасан үүргийг, Академи нь энэ гэрээний 2.1.5, 2.1.8-д заасан үүргээс гадна “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д заасан үүргийг тус тус хэрэгжүүлнэ.

2.3.Хэрэглэгч нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

2.3.1.энэ гэрээнд зааснаас бусад нэмэлт веб сервис ашиглах хүсэлтээ цаасан, эсхүл цахим хэлбэрээр гаргаж, шийдвэрлүүлэх;

2.3.2.“ХУР” системийн техникийн нөхцөл, шаардлагыг хангах талаар гарсан аливаа доголдлыг шийдвэрлүүлэх;

2.3.3.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

2.3.4.“ХУР” системээс авч байгаа мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу ашиглах;



2.3.5. “ХУР” системд холбогдсон тоног төхөөрөмж, сүлжээ, системд төлөвлөгөөт үзлэг, үйлчилгээ болон хяналт, шалгалтын ажлыг хийж гэмтэл, саатал гарсан тохиолдолд даруй засварлах;

2.3.6. “ХУР” системээс мэдээллийг дуудах бүрд хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээллийг дуудаж байгаа тухайн хүн, хуулийн этгээдийн регистрийн дугаар, эсхүл иргэний бүртгэлийн дугаараар таньж тодорхойлох;

2.3.7. хамтран ажиллах явцад олж авсан аливаа мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах;

2.3.8. “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д заасан хамтын ажиллагаа хариуцсан ажилтнаар дамжуулан харилцах, хамтын ажиллагаа хариуцсан ажилтны мэдээллийг журамд заасан гэрээний бүртгэлийн санд бүртгүүлж, өөрчлөлт орсон тухай бүрд даруй мэдэгдэх.

Гурав.Гэрээний хугацаа

3.1.Гэрээний хугацаа нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын 4.6 дахь хэсэгт заасны дагуу 3 жил байна.

3.2.Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлтийг яаманд хүргүүлэх бөгөөд яам нь хугацаа сунгах асуудлыг шийдвэрлэнэ.

3.3.Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

Дөрөв.Гэрээний төлбөр

4.1.Дата төв “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын 4.7-д заасны дагуу тооцсон гэрээний төлбөрийг сар бүрийн 1-ний өдрөөс тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 10-ны өдрийн дотор нэхэмжилнэ.

4.2.Хэрэглэгч нь тухайн сарын төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор Дата төвийн _____ тоот дансанд шилжүүлнэ.

Тав.Давагдашгүй хүчин зүйлс

5.1.“Давагдашгүй хүчин зүйлс” гэж гэрээний талууд урьдчилан таамаглаагүй, мэдэх боломжгүй буюу түүнийг шийдвэрлэхэд бэрхшээлтэй нөхцөл байдал, гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, ажил хаялт, гоц халдварт өвчин, цар тахал дэлгэрэх, улс орныг хамарсан онц бөгөөд дайн бүхий байдал үүсэх, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм тогтоох, удаан хугацааны эрчим хүчний тасалдал зэрэг талуудын санаа зоригоос гадуур үүсэж болох нөхцөлүүдийг ойлгоно.

5.2.Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний нөгөө талд ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх ба үүрэг хүлээх хугацаа нь тухайн нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

5.3.Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд гуравдагч этгээд буюу эрх бүхий байгууллагаас нотолсон баримтыг гаргуулж авна.

5.4.Давагдашгүй хүчин зүйл бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

Зургаа.Талуудын хүлээх хариуцлага

6.1.Талууд энэ гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүссэн аливаа хохирлыг хариуцан, гэрээний нөгөө талд барагдуулна.

6.2.Хэрэглэгч нь энэ гэрээнд заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Дата төв үйлчилгээний хандах эрхийг түр хугацаагаар хязгаарлана.

Долоо.Гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлэх

7.1.Гэрээний талууд гэрээнээс үүссэн аливаа маргааныг үл маргах буюу харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

7.2.Гэрээний талууд харилцан зөвшилцөж чадаагүй тохиолдолд хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

Найм.Бусад зүйлс

8.1.Талууд нь энэ гэрээний 2.2-т зааснаас бусад үүргээ гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр шилжүүлэхгүй.



8.2.Аль нэг тал нь уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах саналтай бол түүнийгээ цаасан, эсхүл цахим хэлбэрээр нөгөө талдаа урьдчилан мэдэгдэж хамтран шийдвэрлэнэ. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж гэрээний нэгэн адил үйлчилнэ.

8.3.Энэ гэрээг талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох ба гэрээг 2 хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.

Ес.Гэрээний хавсралт

9.1.Доорх хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

9.1.1.хавсралт: “_____”-ийн _____“ХУР” системээр дамжуулан хүлээн авах мэдээлэл _____хуудас.

Талуудын хаяг:

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Сүхбаатарын талбай-1, Төв шуудан, Цахим хөгжил, харилцаа холбооны яам.

Утас: +976-11330781

Факс:

Цахим хуудас: www.mddc.gov.mn

Цахим шуудан: info@mddc.gov.mn

Хаяг:

Утас:

Факс:

Цахим хуудас:

Цахим шуудан:

Гэрээ байгуулсан:

Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг: төлөөлж:
төлөөлж:

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

.....(эцэг/эх/-ийн нэр, нэр) (тамга, тэмдэг)

..... (албан тушаал)

.....(эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (тамга, тэмдэг)



Журмын 1 дүгээр хавсралтаар баталсан
гэрээний загварын хавсралт

“.....”-ИЙН “ХУР” СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН ХҮЛЭЭН АВАХ МЭДЭЭЛЭЛ

№	Сервис нэр	Дэлгэрэнгүй тайлбар	Хувьсагч	Оролтын утгууд			Гаралтын утгууд			Зориулалт
				Төрөл	Утга	Тайлбар	Төрөл	Утга	Тайлбар	



БАТЛАВ.

БАТЛАВ.

**ТАНИЛТ, НЭВТРЭЛТИЙН СИСТЕМ АШИГЛАН ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

№ ...

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

Энэхүү гэрээг нэг талаас Цахим хөгжил, харилцаа холбооны яам
(цаашид “яам” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)

Нөгөө талаас _____
(цаашид “Хэрэглэгч” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)
нар (хамтад нь “Талууд” гэх) дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож
байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам, Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

1.2.Энэ гэрээгээр хэрэглэгчийг Танилт, нэвтрэлтийн системд холбож, гэрээний хавсралтад заасан мэдээллийг дамжуулах үед үүсэх харилцааг зохицуулна.

1.3.Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“Танилт, нэвтрэлтийн систем” гэж үндсэн болон Хэрэглэгчийн системийн хэвийн, найдвартай, аюулгүй ажиллагааг хангах зорилго бүхий бие даасан системийг;

1.3.2.“Хэрэглэгч” гэж гэрээ байгуулж байгаа төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийг;



1.3.3. “Үндэсний дата төв” УТҮГ” (цаашид “Дата төв” гэх) гэж Танилт, нэвтрэлтийн системд үйлчилгээний холболтыг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг;

1.3.4. “И-Монгол академи” УТҮГ” (цаашид “Академи” гэх) гэж Танилт, нэвтрэлтийн системийн хөгжүүлэлтийг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг;

1.3.5. “Амжилттай дуудсан сервис” гэж тухайн сервисийг дуудаж байгаа хэрэглэгчид ашиглаж болох хариу буцаасан байхыг.

Хоёр.Талуудын эрх, үүрэг

2.1. Яам нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

2.1.1. гэрээний хэрэгжилтийг хангах;

2.1.2. гэрээний биелэлтийг үнэлэн, гэрээний нөгөө тал болон Дата төв, Академид зөвлөмж хүргүүлэх;

2.1.3. хэрэглэгчийн ашиглаж байгаа систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалт хийх, техникийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэх, зөвлөмж хүргүүлэх;

2.1.4. танилт, нэвтрэлтийн системийн ашиглалт, тогтвортой ажиллагааны нөхцөлийг хангах;

2.1.5. танилт, нэвтрэлтийн системд гарсан аливаа доголдлыг шийдвэрлэх;

2.1.6. хамтран ажиллах явцад олж авсан аливаа мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах.

2.2. Дата төв нь энэ гэрээний 2.1.3-т заасан үүргийг, Академи нь энэ гэрээний 2.1.4, 2.1.5-д заасан үүргээс гадна “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д заасан үүргийг тус тус хэрэгжүүлнэ.

2.3. Хэрэглэгч нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

2.3.1. танилт, нэвтрэлтийн системийн техникийн нөхцөл шаардлагыг хангах талаар гарсан аливаа доголдлыг шийдвэрлүүлэх;

2.3.2. гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

2.3.3. шаардлагатай тохиолдолд танилт, нэвтрэлтийн системд иргэнийг таних үед Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 19.1-д заасны дагуу ашигласан танилт, нэвтрэлтийн арга хэрэгслээр үйлчилгээний цар хүрээг хязгаарлах;

2.3.4. хамтран ажиллах явцад олж авсан аливаа мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах;

2.3.5. “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д заасан хамтын ажиллагаа хариуцсан ажилтнаар дамжуулан харилцах, хамтын ажиллагаа хариуцсан ажилтны мэдээллийг журамд заасан гэрээний бүртгэлийн санд бүртгүүлж, өөрчлөлт орсон тухай бүрд даруй мэдэгдэх.

Гурав. Гэрээний хугацаа

3.1. Гэрээний хугацаа нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын 4.6 дахь хэсэгт заасны дагуу 3 жил байна.

3.2. Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлтийг яаманд хүргүүлэх бөгөөд яам нь хугацаа сунгах асуудлыг шийдвэрлэнэ.

3.3. Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

Дөрөв. Гэрээний төлбөр

4.1. Академи “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын 4.7-д заасны дагуу тооцсон гэрээний төлбөрийг сар бүрийн 1-ний өдрөөс тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 10-ны өдрийн дотор нэхэмжилнэ.

4.2. Хэрэглэгч нь тухайн сарын төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор Академийн _____ тоот дансанд шилжүүлнэ.

Тав.Давагдашгүй хүчин зүйлс

5.1.“Давагдашгүй хүчин зүйлс” гэж гэрээний талууд урьдчилан таамаглаагүй, мэдэх боломжгүй буюу түүнийг шийдвэрлэхэд нэн бэрхшээлтэй нөхцөл байдал, гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, ажил хаялт, гоц халдварт өвчин, цар тахал дэлгэрэх, улс орныг хамарсан онц бөгөөд дайн бүхий байдал үүсэх, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм тогтоох, удаан хугацааны эрчим хүчний тасалдал зэрэг талуудын санаа зоригоос гадуур үүсэж болох нөхцөлүүдийг ойлгоно.

5.2.Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний нөгөө талд ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх ба үүрэг хүлээх хугацаа нь тухайн нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

5.3.Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд гуравдагч этгээд буюу эрх бүхий байгууллагаас нотолсон баримтыг гаргуулж авна.

5.4.Давагдашгүй хүчин зүйл бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

Зургаа.Талуудын хүлээх хариуцлага

6.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүссэн аливаа хохирлыг хариуцан, гэрээний нөгөө талд барагдуулна.

6.2.Хэрэглэгч нь гэрээнд заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Академи нь үйлчилгээний хандах эрхийг түр хугацаагаар хязгаарлана.

Долоо.Гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлэх

7.1.Гэрээнээс үүссэн аливаа маргааныг үл маргах буюу харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

7.2.Гэрээний талууд харилцан зөвшилцөж чадаагүй тохиолдолд хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

Найм.Бусад зүйлс

8.1.Талууд нь энэ гэрээний 2.2-т зааснаас бусад гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр шилжүүлэхгүй.



8.2.Аль нэг тал нь уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах саналтай бол түүнийгээ цаасан, эсхүл цахим хэлбэрээр нөгөө талдаа урьдчилан мэдэгдэж хамтран шийдвэрлэнэ. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж гэрээний нэгэн адил үйлчилнэ.

8.3.Энэ гэрээг талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох ба гэрээг 2 хувь үйлдэж, тус бүр нэг, нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.

Ес.Гэрээний хавсралт

9.1.Доорх хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

9.1.1.хавсралт: “_____”-ийн _____ домейнд “ХУР” системээр дамжуулан хүлээн авах мэдээлэл _____ хуудас.

Талуудын хаяг:

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Сүхбаатарын талбай-1, Төв шуудан, Цахим хөгжил, харилцаа холбооны яам.

Утас: +976-11330781

Факс:

Цахим хуудас: www.mddc.gov.mn

Цахим шуудан: info@mddc.gov.mn

Хаяг:

Утас:

Факс:

Цахим хуудас:

Цахим шуудан:

Гэрээ байгуулсан:

Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг: төлөөлж:
төлөөлж:

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал) (тамга, тэмдэг)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

(тамга, тэмдэг)



Журмын 2 дугаар хавсралтаар баталсан
гэрээний загварын хавсралт

“.....” –ИЙН ДӨМЭЙНД “ХУР” СИСТЕМЭЭР ДАМЖУУЛАН ХҮЛЭЭН АВАХ МЭДЭЭЛЭЛ

№	Сервис нэр	Дэлгэрэнгүй тайлбар	Хувьсагч	Оролтын утгууд			Гаралтын утгууд			Зориулалт
				Төрөл	Утга	Тайлбар	Төрөл	Утга	Тайлбар	



БАТЛАВ.

БАТЛАВ.

**АЛБАН БИЧИГ СОЛИЛЦООНЫ ДУНДЫН СИСТЕМ АШИГЛАН
ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

№ ...

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

Энэхүү гэрээг нэг талаас Цахим хөгжил, харилцаа холбооны яам
(цаашид “яам” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)

Нөгөө талаас _____
(цаашид “Хэрэглэгч” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)
нар (хамтад нь “Талууд” гэх) дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож
байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам, Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал, Төрийн байгууллагуудад хэрэглэх архив, албан хэрэг хөтлөлтийн программ хангамжид тавигдах нийтлэг шаардлага, цахим хэлбэрээр албан хэрэг хөтлөх нийтлэг журам, болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

1.2.Энэ гэрээгээр хэрэглэгчийг Албан бичиг солилцооны дундын системд холболт хийх үед үүсэх харилцааг зохицуулна.

1.3.Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“Албан бичиг солилцооны дундын систем” гэж Хэрэглэгч хоорондоо албаны цахим шуудангаас бусад хэлбэрээр цахимаар албан бичиг илгээх, хүлээн авахдаа ашиглах боломж бүхий системийг;

1.3.2.“Хэрэглэгч” гэж гэрээ байгуулж байгаа төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийг;



1.3.3. “И-Монгол академи” УТҮГ” (цаашид “Академи” гэх) гэж Албан бичиг солилцооны дундын системийн хөгжүүлэлтийг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг;

1.3.4. “Тоон гарын үсэг” гэж Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.2-т заасныг;

1.3.5. “Дотоод удирдлагын систем” гэж хэрэглэгч байгууллагын ашигладаг албан бичиг цахимаар солилцох системийг;

1.3.6. “Хэрэглэгчийн токен” гэж албан бичиг солилцооны дундын системд холбогдох үед Академиас үүсгэж өгсөн мэдээллийг.

Хоёр.Талуудын эрх, үүрэг

2.1. Яам нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

2.1.1. гэрээний хэрэгжилтийг хангах;

2.1.2. гэрээний биелэлтийг үнэлэн, гэрээний нөгөө тал болон Академид зөвлөмж хүргүүлэх;

2.1.3. хэрэглэгчийн ашиглаж байгаа систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалт хийх, техникийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэх, зөвлөмж хүргүүлэх;

2.1.4. албан бичиг солилцооны дундын системд хэрэглэгч байгууллагыг холбож, хэрэглэгчийн токеныг үүсгэн хамтын ажиллагаа хариуцсан ажилтанд нууцлалтайгаар илгээх;

2.1.5. хэрэглэгчийн дотоод удирдлагын системд хэрэглэгчийн токеныг оруулж, албан бичиг солилцооны дундын системд холбогдох зааварчилгааг өгөх;

2.1.6. албан бичиг солилцооны дундын системийн ашиглалт, үйлчилгээний аюулгүй байдал, тогтвортой ажиллагааны нөхцөлийг хангах;

2.1.7. албан бичиг солилцооны дундын системийн хөгжүүлэлтийг хариуцах;

2.1.8. албан бичиг солилцооны дундын системд гарсан аливаа доголдлыг шийдвэрлэх;

2.1.9. хамтран ажиллах явцад олж авсан аливаа мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах.

2.2.Академи нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д заасан үүргээс гадна энэ гэрээний 2.1.3, 2.1.4, 2.1.5, 2.1.6, 2.1.7, 2.1.8-д заасан үүргийг хариуцна.

2.3.Хэрэглэгч нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

2.3.1.албан бичиг солилцооны дундын системийн техникийн нөхцөл, шаардлагыг хангах талаар гарсан аливаа доголдлыг шийдвэрлүүлэх;

2.3.2.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

2.3.3.Академиас илгээсэн хэрэглэгчийн токеныг нууцалж, дотоод удирдлагын системээс бусад системд ашиглаж, дамжуулахгүй байх;

2.3.4.хамтран ажиллах явцад олж авсан аливаа мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах;

2.3.5.“Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д заасан хамтын ажиллагаа хариуцсан ажилтнаар дамжуулан харилцах, хамтын ажиллагаа хариуцсан ажилтны мэдээллийг журамд заасан гэрээний бүртгэлийн санд бүртгүүлж, өөрчлөлт орсон тухай бүрд даруй мэдэгдэх.

Гурав.Гэрээний хугацаа

3.1.Гэрээний хугацаа нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын 4.6 дахь хэсэгт заасны дагуу 3 жил байна.

3.2.Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлтийг яаманд хүргүүлэх бөгөөд яам нь хугацаа сунгах асуудлыг шийдвэрлэнэ.

3.3.Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

Дөрөв.Гэрээний төлбөр

4.1.Академи “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын 4.7-д



заасны дагуу тооцсон гэрээний төлбөрийг сар бүрийн 1-ний өдрөөс тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 10-ны өдрийн дотор нэхэмжилнэ.

4.2.Хэрэглэгч нь тухайн сарын төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор Академийн _____ тоот дансанд шилжүүлнэ.

Тав.Давагдашгүй хүчин зүйлс

5.1.“Давагдашгүй хүчин зүйлс” гэж гэрээний талууд урьдчилан таамаглаагүй, мэдэх боломжгүй буюу түүнийг шийдвэрлэхэд нэн бэрхшээлтэй нөхцөл байдал, гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, ажил хаялт, гоц халдварт өвчин, цар тахал дэлгэрэх, улс орныг хамарсан онц бөгөөд дайн бүхий байдал үүсэх, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм тогтоох, удаан хугацааны эрчим хүчний тасалдал зэрэг талуудын санаа зоригоос гадуур үүсэж болох нөхцөлүүдийг ойлгоно.

5.2.Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний нөгөө талд ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх ба үүрэг хүлээх хугацаа нь тухайн нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

5.3.Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд гуравдагч этгээд буюу эрх бүхий байгууллагаас нотолсон баримтыг гаргуулж авна.

5.4.Давагдашгүй хүчин зүйл бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

Зургаа.Талуудын хүлээх хариуцлага

6.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүссэн аливаа хохирлыг хариуцан, гэрээний нөгөө талд барагдуулна.

6.2.Хэрэглэгч нь гэрээнд заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Академи нь үйлчилгээний хандах эрхийг түр хугацаагаар хязгаарлана.

Долоо.Гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлэх

7.1.Гэрээнээс үүссэн аливаа маргааныг үл маргах буюу харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.



7.2.Гэрээний талууд харилцан зөвшилцөж чадаагүй тохиолдолд хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

Найм.Бусад зүйлс

8.1.Талууд нь энэ гэрээний 2.2-т зааснаас бусад гэрээгээр хүлээсэн үүргээ гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр шилжүүлэхгүй.

8.2.Аль нэг тал нь уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах саналтай бол түүнийгээ цаасан, эсхүл цахим хэлбэрээр нөгөө талдаа урьдчилан мэдэгдэж хамтран шийдвэрлэнэ. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж гэрээний нэгэн адил үйлчилнэ.

8.3.Энэ гэрээг талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох ба гэрээг 2 хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.

Талуудын хаяг:

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, Сүхбаатарын талбай-1, Төв шуудан, Цахим хөгжил, харилцаа холбооны яам.

Утас: +976-11330781

Факс:

Цахим хуудас: www.mddc.gov.mn

Цахим шуудан: info@mddc.gov.mn

Хаяг:

Утас:

Факс:

Цахим хуудас:

Цахим шуудан:

Гэрээ байгуулсан:

Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг: төлөөлж:
төлөөлж:

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

(тамга, тэмдэг)

(тамга, тэмдэг)

БАТЛАВ.

БАТЛАВ.

**МЭДЭГДЭЛ ХҮРГЭХ СИСТЕМ АШИГЛАН ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР**

№ ...

2022 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

Энэхүү гэрээг нэг талаас Цахим хөгжил, харилцаа холбооны яам
(цаашид “яам” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)

Нөгөө талаас _____
(цаашид “Хэрэглэгч” гэх), түүнийг төлөөлж _____
(албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)
нар (хамтад нь “Талууд” гэх) дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож
байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам, Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

1.2.Энэ гэрээгээр хэрэглэгчийг Мэдэгдэл хүргэх системд холболт хийх үед үүсэх харилцааг зохицуулна.

1.3.Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“Мэдэгдэл хүргэх систем” гэж цахим хэлбэрээр мэдэгдэл хүргэхэд ашиглах системийг;

1.3.2.“Хэрэглэгч” гэж гэрээ байгуулж байгаа төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийг;

1.3.3.“Үндэсний дата төв” УТҮГ” (цаашид “Дата төв” гэх) гэж Мэдэгдэл хүргэх системийн ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг;

1.3.4. “И-Монгол академи” УТҮГ” (цаашид “Академи” гэх) гэж Мэдэгдэл хүргэх системийн хөгжүүлэлтийг хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг.

Хоёр.Талуудын эрх, үүрэг

2.1.Яам нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

2.1.1.гэрээний хэрэгжилтийг хангах;

2.1.2.гэрээний биелэлтийг үнэлэн, гэрээний нөгөө тал болон Дата төв, Академид зөвлөмж хүргүүлэх;

2.1.3.хэрэглэгчийн ашиглаж байгаа систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалт хийх, техникийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэх, зөвлөмж хүргүүлэх;

2.1.4.хэрэглэгчид мэдэгдлийг хүргэх нөхцөлийг бүрдүүлж, эрх нээж өгөх, холбогдох ажилтнуудад заавар, зөвлөмж хүргэх;

2.1.5.мэдэгдэл хүргэх системийн хэвийн, аюулгүй ажиллагааг хангаж, хяналт тавьж, холбогдох хөгжүүлэлтийг хийх;

2.1.6.мэдэгдэл хүргэх системд гарсан аливаа доголдлыг шийдвэрлэх;

2.1.7.хамтран ажиллах явцад олж авсан аливаа мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах.

2.2.Дата төв нь энэ гэрээний 2.1.3-т заасан үүргийг, Академи нь энэ гэрээний 2.1.4, 2.1.5, 2.1.6-д заасан үүргээс гадна “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д заасан үүргийг тус тус хэрэгжүүлнэ.

2.3.Хэрэглэгч нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

2.3.1.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

2.3.2.мэдэгдэл хүргэх системийг ашиглах, системд холбогдох зааварчилгаа, мэдээлэл авах;

2.3.3.мэдэгдэл хүргэх системийн техникийн нөхцөл, шаардлагыг хангах талаар гарсан аливаа доголдлыг шийдвэрлүүлэх;



2.3.4. хамтран ажиллах явцад олж авсан аливаа мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах;

2.3.5. “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д заасан хамтын ажиллагаа хариуцсан ажилтнаар дамжуулан харилцах, хамтын ажиллагаа хариуцсан ажилтны мэдээллийг журамд заасан гэрээний бүртгэлийн санд бүртгүүлж, өөрчлөлт орсон тухай бүрд даруй мэдэгдэх.

Гурав. Гэрээний хугацаа

3.1. Гэрээний хугацаа нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын 4.6 дахь хэсэгт заасны дагуу 3 жил байна.

3.2. Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлтийг яаманд хүргүүлэх бөгөөд яам нь хугацаа сунгах асуудлыг шийдвэрлэнэ.

3.3. Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

Дөрөв. Гэрээний төлбөр

4.1. Дата төв “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын 4.7-д заасны дагуу тооцсон гэрээний төлбөрийг сар бүрийн 1-ний өдрөөс тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 10-ны өдрийн дотор нэхэмжилнэ.

4.2. Хэрэглэгч нь тухайн сарын төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор Дата төвийн _____ тоот дансанд шилжүүлнэ.

Тав. Давагдашгүй хүчин зүйлс

5.1. “Давагдашгүй хүчин зүйлс” гэж гэрээний талууд урьдчилан таамаглаагүй, мэдэх боломжгүй буюу түүнийг шийдвэрлэхэд нэн бэрхшээлтэй нөхцөл байдал, гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, ажил хаялт, гоц халдварт өвчин, цар тахал дэлгэрэх, улс орныг хамарсан онц бөгөөд дайн бүхий байдал үүсэх, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм тогтоох, удаан хугацааны эрчим хүчний тасалдал зэрэг талуудын санаа зоригоос гадуур үүсэж болох нөхцөлүүдийг ойлгоно.



5.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний нөгөө талд ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх ба үүрэг хүлээх хугацаа нь тухайн нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

5.3. Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд гуравдагч этгээд буюу эрх бүхий байгууллагаас нотолсон баримтыг гаргуулж авна.

5.4. Давагдашгүй хүчин зүйл бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

Зургаа. Талуудын хүлээх хариуцлага

6.1. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүссэн аливаа хохирлыг хариуцан, гэрээний нөгөө талд барагдуулна.

6.2. Хэрэглэгч нь гэрээнд заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Дата төв нь үйлчилгээний хандах эрхийг түр хугацаагаар хязгаарлана.

Долоо. Гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлэх

7.1. Гэрээнээс үүссэн аливаа маргааныг үл маргах буюу харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

7.2. Гэрээний талууд харилцан зөвшилцөж чадаагүй тохиолдолд хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

Найм. Бусад зүйлс

8.1. Талууд энэ гэрээний 2.2-т зааснаас бусад үүргээ гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр шилжүүлэхгүй.

8.2. Аль нэг тал нь уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах саналтай бол түүнийг цаасан, эсхүл цахим хэлбэрээр нөгөө талдаа урьдчилан мэдэгдэж хамтран шийдвэрлэнэ. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж гэрээний нэгэн адил үйлчилнэ.

8.3. Энэ гэрээг талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох ба гэрээг 2 хувь үйлдэж, тус бүр нэг, нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.



Талуудын хаяг:

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энх тайвны өргөн чөлөө, Сүхбаатарын талбай-1, Төв шуудан, Цахим хөгжил, харилцаа холбооны яам.

Утас: +976-11330781

Факс:

Цахим хуудас: www.mddc.gov.mn

Цахим шуудан: info@mddc.gov.mn

Хаяг.....

Утас:

Факс:

Цахим хуудас:

Цахим шуудан:

Гэрээ байгуулсан:

Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг төлөөлж:

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр) (тамга, тэмдэг)

..... (албан тушаал)

.....(эцэг/эх/-ийн нэр, нэр)

(тамга, тэмдэг)

Журмын 5 дугаар хавсралт

БАТЛАВ.

БАТЛАВ.

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМ АШИГЛАН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭНИЙ ЗАГВАР

№ ...

2022 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

Энэхүү гэрээг нэг талаас Цахим хөгжил, харилцаа холбооны яам (цаашид “яам” гэх), түүнийг төлөөлж _____ (албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)

Нөгөө талаас _____ (цаашид “Хэрэглэгч” гэх), түүнийг төлөөлж _____ (албан тушаал, эцэг/эх/-ийн нэр, нэр)

нар (хамтад нь “Талууд” гэх) дор дурдсан нөхцөлийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхдээ Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, “И-Монгол академи” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, “Үндэсний дата төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам, Үндсэн систем, дэмжих системийн техникийн нөхцөл, шаардлага, заавар, аргачлал болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

1.2.Энэхүү гэрээгээр хэрэглэгчийг Төрийн үйлчилгээний нэгдсэн системд холбох үед үүсэх харилцааг зохицуулна.

1.3.Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.3.1.“Төрийн үйлчилгээний нэгдсэн систем” гэж нийтийн мэдээлэл, төрийн болон бусад үйлчилгээг цахим хэлбэрээр хүргэх системийг;

1.3.2.“Хэрэглэгч” гэж гэрээ байгуулж байгаа төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийг;

1.3.3.“И-Монгол академи” УТҮГ” (цаашид “Академи” гэх) гэж Төрийн үйлчилгээний нэгдсэн системийн хөгжүүлэлт хийн, ашиглах нөхцөлийг бүрдүүлж ажиллах байгууллагыг.

Хоёр.Талуудын эрх, үүрэг

2.1.Яам нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

2.1.1.гэрээний хэрэгжилтийг хангах;

2.1.2.гэрээний биелэлтийг үнэлэн, гэрээний нөгөө тал болон Академид зөвлөмж хүргүүлэх;

2.1.3.хэрэглэгчийн ашиглаж байгаа систем, сүлжээнд техникийн үзлэг, шалгалт хийх, техникийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэх, зөвлөмж хүргүүлэх;

2.1.4.төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглах, системд холбогдох зааварчилгаа, мэдээллийг өгөх;

2.1.5.төрийн үйлчилгээний нэгдсэн системд гарсан аливаа доголдлыг шийдвэрлэх;

2.1.6.хамтран ажиллах явцад олж авсан аливаа мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах.

2.2.Академи нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д заасан үүргээс гадна энэ гэрээний 2.1.3, 2.1.4, 2.1.5-д заасан үүргийг хариуцна.

2.3.Хэрэглэгч нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д зааснаас гадна дараах эрх, үүрэгтэй:

2.3.1.гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах;

2.3.2.төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглах, системд холбогдох зааварчилгаа, мэдээлэл авах;

2.3.3.төрийн үйлчилгээний нэгдсэн системийн техникийн нөхцөл, шаардлагыг хангах талаар гарсан аливаа доголдлыг шийдвэрлүүлэх;

2.3.4.хамтран ажиллах явцад олж авсан аливаа мэдээ, мэдээллийн нууцыг хадгалах;

2.3.5.төрийн үйлчилгээний нэгдсэн системийг ашиглан үйлчилгээ үзүүлэхэд өөрийн хариуцаж байгаа сервис, дэд системийн хэвийн, аюулгүй ажиллагааг хариуцаж ажиллах;

2.3.6.“Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-д заасан хамтын ажиллагаа хариуцсан ажилтнаар дамжуулан харилцах, хамтын ажиллагаа хариуцсан ажилтны мэдээллийг журамд заасан гэрээний бүртгэлийн санд бүртгүүлж, өөрчлөлт орсон тухай бүрд даруй мэдэгдэх.

Гурав.Гэрээний хугацаа

3.1.Гэрээний хугацаа нь “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын 4.6 дахь хэсэгт заасны дагуу 3 жил байна.

3.2.Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлтийг яаманд хүргүүлэх бөгөөд яам нь хугацаа сунгах асуудлыг шийдвэрлэнэ.



3.3.Хэрэглэгч энэ гэрээний 3.1-д заасан хугацааг сунгах тухай хүсэлт ирүүлээгүй тохиолдолд гэрээг анх байгуулсан хугацаагаар сунгагдсанд тооцно.

Дөрөв.Гэрээний төлбөр

4.1.Академи “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын 4.7-д заасны дагуу тооцон гэрээний төлбөрийг сар бүрийн 1-ний өдрөөс тухайн сарын сүүлийн өдрөөр тасалбар болгон дараа сарын 10-ны өдрийн дотор нэхэмжилнэ.

4.2.Хэрэглэгч нь тухайн сарын төлбөрийг дараа сарын 20-ны өдрийн дотор Академийн _____ тоот дансанд шилжүүлнэ.

Тав.Давагдашгүй хүчин зүйлс

5.1.“Давагдашгүй хүчин зүйлс” гэж гэрээний талууд урьдчилан таамаглаагүй, мэдэх боломжгүй буюу түүнийг шийдвэрлэхэд нэн бэрхшээлтэй нөхцөл байдал, гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, үймээн самуун, ажил хаялт, гоц халдварт өвчин, цар тахал дэлгэрэх, улс орныг хамарсан онц бөгөөд дайн бүхий байдал үүсэх, террорист халдлага, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио цээрийн дэглэм тогтоох, удаан хугацааны эрчим хүчний тасалдал зэрэг талуудын санаа зоригоос гадуур үүсэж болох нөхцөлүүдийг ойлгоно.

5.2.Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас талуудын аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний нөгөө талд ажлын 3 өдрийн дотор мэдэгдэх ба үүрэг хүлээх хугацаа нь тухайн нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

5.3.Давагдашгүй хүчин зүйл үүссэн тохиолдолд гуравдагч этгээд буюу эрх бүхий байгууллагаас нотолсон баримтыг гаргуулж авна.

5.4.Давагдашгүй хүчин зүйл бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

Зургаа.Талуудын хүлээх хариуцлага

6.1.Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс үүссэн аливаа хохирлыг хариуцан, гэрээний нөгөө талд барагдуулна.

6.2.Хэрэглэгч нь гэрээнд заасан төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд Академи нь үйлчилгээний хандах эрхийг түр хугацаагаар хязгаарлана.

Долоо.Гэрээнээс үүдэлтэй маргаан шийдвэрлэх

7.1.Гэрээнээс үүссэн аливаа маргааныг үл маргах буюу харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

7.2.Гэрээний талууд харилцан зөвшилцөж чадаагүй тохиолдолд хуульд заасан журмын дагуу шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

Найм.Бусад зүйлс

8.1.Талууд нь энэ гэрээний 2.2-т зааснаас бусад үүргээ гуравдагч этгээдэд хэсэгчлэн болон бүрэн хэмжээгээр шилжүүлэхгүй.

8.2.Талууд нь өгөгдөл дамжуулахад ашиглаж байгаа серверийн байршил өөрчлөгдөж, хоорондын сүлжээний холболтыг өөрчлөх, шилжүүлэхтэй холбоотой мэдэгдлийг ажлын 3-аас доошгүй хоногийн өмнө хүргэх бөгөөд аливаа зардлыг тухайн өөрчлөлт, шилжүүлэлт хийж байгаа тал хариуцна.

8.3.Аль нэг тал нь уг гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах саналтай бол түүнийгээ цаасан, эсхүл цахим хэлбэрээр нөгөө талдаа урьдчилан мэдэгдэж хамтран шийдвэрлэнэ. Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг бичгээр үйлдэж, талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болж гэрээний нэгэн адил үйлчилнэ.

8.4.Энэ гэрээг талууд гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох ба гэрээг 2 хувь үйлдэж, тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн хувьд ижил хүчинтэй байна.

Ес.Гэрээний хавсралт

9.1.Доорх хавсралт нь гэрээний салшгүй хэсэг байна.

9.1.1.хавсралт: Төрийн үйлчилгээний нэгдсэн системээр үзүүлэх _____ үйлчилгээний мэдээлэл_____хуудас.



Талуудын хаяг:

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энх тайвны өргөн чөлөө, Сүхбаатарын талбай-1, Төв шуудан, Цахим хөгжил, харилцаа холбооны яам.

Утас: +976-11330781

Факс:

Цахим хуудас: www.mddc.gov.mn

Цахим шуудан: info@mddc.gov.mn

Хаяг:

Утас:

Факс:

Цахим хуудас:

Цахим шуудан:

Гэрээ байгуулсан:

Цахим хөгжил, харилцаа холбооны яамыг: төлөөлж:
төлөөлж:

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр) (тамга, тэмдэг)

..... (албан тушаал)

..... (эцэг/эх/-ийн нэр, нэр)

(тамга, тэмдэг)

Журмын 5 дугаар хавсралтаар баталсан
гэрээний загварын хавсралт

**ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НЭГДСЭН СИСТЕМЭЭР
ҮЗҮҮЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

№	Үйлчилгээний нэр	Ангилал	Үйлчилгээний хураамж	Үзүүлэх горим			Шийдвэрлэх хугацаа
				Вэб портал	Гар утасны аппликэйшн	Оператор	
1							
2							
3							



ҮНДСЭН БОЛОН ДЭМЖИХ СИСТЕМ АШИГЛАН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХЭД ЗАРДАЛ ТООЦОХ АРГАЧЛАЛ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ аргачлалыг “Үндэсний дата төв” УТҮГ болон “И-Монгол академи” УТҮГ нь үндсэн болон дэмжих системээр дамжуулан хүн, хуулийн этгээдэд үзүүлж байгаа үйлчилгээний зардлыг тооцоход баримтална.

Хоёр.Үндсэн болон дэмжих систем ашиглан үзүүлэх үйлчилгээний зардал тооцох

2.1.Үндсэн болон дэмжих систем ашиглан үзүүлэх үйлчилгээний зардлыг “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын 4.7-д заасны дагуу “Үндэсний дата төв” УТҮГ болон “И-Монгол академи” УТҮГ тооцох бөгөөд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

Гурав.Зардал тооцох аргачлал

3.1.Зардлыг тооцохдоо “Өртөгт суурилсан арга”-ын “Дээрээс доош” аргачлалыг баримталж, зардлыг өртөгт суурилан бүрэн хуваарилах зарчимд үндэслэнэ.

3.2.“Дээрээс доош” аргачлал нь дараах 5 үе шатаас бүрдэнэ:

3.2.1.байгууллагын үйлчилгээний төрлүүдийг тодорхойлох;

3.2.2.бүх зардал ба хөрөнгийг тодорхойлох бөгөөд салгах;

3.2.3.шууд хамаарах бүх зардлыг хуваарилах;

3.2.4.нийтлэг болон хуваагдах боломжтой зардлуудыг дахин хуваарилах;

3.2.5.нэгжийн өртөг тооцоолох.

3.3.Энэ журмын 3.2-т заасан аргачлал нь байгууллагын одоогийн үйл ажиллагааны зардалд тулгуурлана.



**Дөрөв.Байгууллагын үйлчилгээний
төрлүүдийг тодорхойлох**

4.1.Байгууллагын үйлчилгээний төрлийг төлбөртэй болон төлбөргүй байдлаар тодорхойлох бөгөөд үйлчилгээний төрлийг жишээ байдлаар Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1

Байгууллагын үзүүлж байгаа үйлчилгээний төрөл

№	Үйлчилгээний нэр, төрөл	Төлбөртэй	Төлбөргүй
1	Үйлчилгээ 1		*
2	Үйлчилгээ 2		*
3	Үйлчилгээ 3		*
4	Үйлчилгээ 4	*	*

Тайлбар: Дээрх үйлчилгээг “Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам”-ын дагуу төрийн байгууллагад үнэ төлбөргүй үзүүлэх бөгөөд хүн, хуулийн этгээдэд тодорхой төлбөртэйгээр үзүүлнэ.

**Тав.Бүх зардал ба хөрөнгийг
тодорхойлох бөгөөд салгах**

5.1.Нийт зардал болон бүртгэлд байгаа хөрөнгийг тодорхойлж ялган, нэгж өртөг тооцох үйлчилгээнд хамаарах шууд болон шууд бус зардлыг бусад зардал, хөрөнгөөс салган дараах байдлаар тооцно:

5.1.1.үнэ тогтоох шаардлага бүхий үйлчилгээнд хамаарах хөрөнгө болон шууд зардлыг бусад зардал, хөрөнгөөс салгах;

5.1.2.бусад хөрөнгийн элэгдлийн зардлыг шууд бус зардал гэж үзэн бүх үйлчилгээнд хуваарилах.

Зургаа.Шууд хамаарах бүх зардлыг хуваарилах

6.1.Байгууллагын хэмжээнд гарч байгаа нийт зардлаас шууд болон шууд бус зардалд хуваарилагдах зардлын төрлийг сонгож, бодит гүйцэтгэлд суурилан хуваарилах бөгөөд жишээг Хүснэгт 2-т, шууд зардлыг үйлчилгээнд хуваарилсан жишээг Хүснэгт 3-т үзүүлэв.



Хүснэгт 2

**Зардлын ангилал, шууд хамаарагдах зардлыг
холбогдох үйлчилгээнд хуваарилах**

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Зардлын дүн	Шууд зардал	Шууд бус зардал
Зардлын төрөл 1					
1	Зардал 1	*	*	*	*
2	Зардал 2	*	*	*	*
3	Зардал 3	*	*	*	*
	Нийт	*	*	*	*
Зардлын төрөл 2					
1	Зардал 1	*	*	*	*
2	Зардал 2	*	*	*	*
3	Зардал 3	*	*	*	*
	Нийт	*	*	*	*
	Нийт дүн	*	*	*	*

Хүснэгт 3

Шууд зардлыг үйлчилгээнд хуваарилсан байдал

№	Зардлын төрөл	Шууд зардал	Үйлчилгээ 1	Үйлчилгээ 2
Зардлын төрөл 1				
1	Зардал 1	*	*	*
2	Зардал 2	*	*	*
3	Нийт	*	*	*
Зардлын төрөл 2				
1	Зардал 1	*	*	*
2	Зардал 2	*	*	*
3	Нийт	*	*	*
	Нийт дүн	*	*	*

**Долоо.Нийтлэг болон хуваагдах боломжтой
зардлуудыг дахин хуваарилах**

7.1.Байгууллагын нийт зардлаас тухайн үйлчилгээнд хамаарах зардлыг тооцоолон ялгаж, үлдэх зардлыг шууд бус зардалд хуваарилна.



Шууд бус зардлууд нь тухайн үйлчилгээ болон бусад үйлчилгээнд хуваарилагдах замаар зардлын чиглүүлэгчийг тодорхойлох бөгөөд жишээг Хүснэгт 4-т үзүүлэв.

7.2. Шууд бус зардлыг Зардлын чиглүүлэгчийг ашиглан үйлчилгээ тус бүрээр тооцох бөгөөд жишээг Хүснэгт 5-д үзүүлэв.

7.3. Зардлын чиглүүлэгчид үндэслэн шууд бус зардлыг үйлчилгээ тус бүрд хуваарилах бөгөөд жишээг Хүснэгт 6-д үзүүлэв.

7.4. Тухайн үйлчилгээнд хамаарах шууд болон шууд бус зардал, хөрөнгө оруулалтын зардлыг нэгтгэж тооцох бөгөөд жишээг Хүснэгт 7-д үзүүлэв.

Хүснэгт 4

Шууд бус зардлуудыг хуваарилах үйлчилгээний төрөл

№	Үзүүлэлт	Үйлчилгээ 1	Үйлчилгээ 2	Бусад
1	Шууд бус зардал 1	*	*	*
2	Шууд бус зардал 2	*	*	*
3	Шууд бус зардал 3	*	*	*
	Нийт зардлын дүн	*	*	*

Хүснэгт 5

Зардлын чиглүүлэгч

Үйл ажиллагааны зардлын төрөл	Зардлын чиглүүлэгч
Зардлын төрөл 1	Чиглүүлэгч 1
Зардлын төрөл 2	Чиглүүлэгч 2
Зардлын төрөл 3	Чиглүүлэгч 3

Тайлбар: Зардлын чиглүүлэгчийг ажилчдын тоонд үндэслэн хуваарилах нь илүү оновчтой. Учир нь тухайн байгууллагад ажиллаж байгаа ажилтан, албан хаагчид тухайн байгууллагын нийт үйл ажиллагаанд бүгд хамааралтай бөгөөд үүнтэй холбоотойгоор зардлын хуваарилагч байх бүрэн боломжтой. Харин эд хогшил, урсгал засварын зардал болон элэгдлийн зардлын чиглүүлэгч нь тухайн хөрөнгөд эзлэх хувийн жингээр тодорхойлогдох нь илүү оновчтой.



Хүснэгт 6

Шууд бус зардлыг хуваарилах

Үйл ажиллагааны зардлын төрөл	Зардлын чиглүүлэгч	Үйлчилгээ 1	Үйлчилгээ 2	Бусад үйлчилгээ
Зардлын төрөл 1	Чиглүүлэгч 1	*	*	*
Зардлын төрөл 2	Чиглүүлэгч 2	*	*	*
Нийт дүн		*	*	*

Хүснэгт 7

Хөрөнгө оруулалт болон зардлын нэгтгэл

№	Зардлын төрөл	Үйлчилгээ 1	Үйлчилгээ 2	Нийт дүн
1	Үндсэн хөрөнгөд хийсэн санхүүжилт	*	*	*
2	Шууд зардал	*	*	*
3	Шууд бус зардал	*		*
Нийт дүн				*

Найм.Нэгжийн өртөг тооцоолох

8.1.Нэгжийн өртгийг тооцоолохдоо тухайн үйлчилгээнд хуваарилагдсан бүх зардлыг нэгжийн суурь үзүүлэлтэд харьцуулна:

8.1.1.Нэгжийн өртөг = Нэгж үйлчилгээний зардлын нийт дүн/Нэгжийн суурь үзүүлэлт.

8.2.Нэгжийн суурь үзүүлэлтийг тооцоолохдоо:

8.2.1.Үндсэн системийн хувьд “ХУР”-д холбогдож амжилттай дуудсан хандалтаас хамаарна;

8.2.2.Дэмжих системийн хувьд систем тус бүрийн онцлогоос шалтгаалж үйлчилгээ авч байгаа хүн, хуулийн этгээдийн тоо, ашиглагдаж байгаа системийн тоо, илгээгдсэн мэдэгдлийн тоо, амжилттай үйлчилгээ авсан нийт тооноос хамаарна.

---o0o---



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 02 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 07

Улаанбаатар
хот

Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг тайлбарлах тухай

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдөр баталсан Өршөөл үзүүлэх тухай хуулийн /цаашид Өршөөл үзүүлэх тухай хуулийн гэх/ 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан журмаар өршөөн хэлтрүүлэх эсэх асуудлыг шат шатны шүүх өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж, өршөөн хэлтрүүлсэн, эсхүл өршөөлд хамааруулахгүй шийдвэрлэсний улмаас шүүхийн практикт хууль хэрэглээний зөрүүтэй байдал үүссэн нь анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрүүдээр илэрсэн байна.

Тухайлбал, Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 282 болон 285 дугаар тогтоолоор шүүгдэгч К.С, Б.Н нарт анхан шатны шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар оногдуулсан торгох ялыг Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар тус тус өршөөн хэлтрүүлсэн бол Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 09 дүгээр тогтоолоор шүүгдэгч Г.Н-д анхан шатны шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар оногдуулсан торгох ялыг Өршөөл үзүүлэх тухай хуульд хамааруулахгүйгээр зөрүүтэй шийдвэрлэжээ.

Иймд хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсгийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах хэрэгцээ, шаардлага үүссэн, энэ талаар Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимаас гаргасан саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж, тайлбарын цар хүрээ, тайлбар гаргах арга зүйг зөвшөөрсөн бөгөөд Өршөөл үзүүлэх тухай хууль болон хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, уг хуулийн төслийг хэлэлцсэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл, Өршөөл үзүүлэх тухай хуулийг хэрэглэсэн шүүхийн шийдвэрүүдэд Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс хийсэн судалгааны дүнг тус тус харьцуулан шинжилж үзэхэд дараах нөхцөл байдал тогтоогдов.

1.Хууль тогтоогч Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 7.1, 7.2, 7.3, 9.1, 9.2-т зааснаас бусад гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн ялтны шүүхээс оногдуулсан, эсхүл эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ” гэж өршөөлд хамрагдах болон хамааруулахгүй гэмт хэргийг тодорхой заажээ.

2.Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт оногдуулсан ялыг бүхэлд нь өршөөн хэлтрүүлэхгүйгээр ялтны шүүхээс оногдуулсан хорих ялын эдлээгүй үлдсэн хэсгийг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольж эдлүүлэхээр заахдаа уг зохицуулалтын зорилгыг “коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор” гэж нарийвчлан тодорхойлсон байна.

3.Өршөөлд хамааруулахгүй гэмт хэрэг, эрүүгийн хариуцлагын төрлийг Өршөөл үзүүлэх тухай хуулийн Гуравдугаар бүлгийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсэгт тусгайлан зааснаас гадна урьд нь гэмт хэрэг үйлдэж, 1991-2015 оны хооронд батлагдсан 6 удаагийн Өршөөл үзүүлэх тухай хуулийн аль нэгэнд хамрагдан хорих ялаас чөлөөлөгдсөнөөс хойш санаатай гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн хүнийг өршөөлд хамааруулахгүй болохыг уг хуулийн Нэгдүгээр бүлгийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт хуульчилжээ.

Ийнхүү хууль тогтоогч “Өршөөл үзүүлэх хэлбэр, хүрээ, хэмжээ”-г тодорхойлсон 4 дүгээр зүйл /Эрүүгийн хариуцлагаас өршөөн хэлтрүүлэх/ болон 5 дугаар зүйл /Зарим хугацаа болон эрүүгийн хэргийг өршөөн хэрэгсэхгүй болгох/-д “Энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 7.1, 7.2, 7.3, 9.1, 9.2-т зааснаас бусад гэмт хэрэг...” гэсэн хууль зүйн техник ашиглахдаа дээрх зүйлүүдэд заасан өршөөлд хамаарахгүй зарим гэмт хэргийг уг хуулийн Гуравдугаар бүлэг /Өршөөлд хамааруулахгүй нөхцөл/-т давхар зохицуулаагүй орхигдуулсан нь шүүхийн практикт ойлгомжгүй байдлыг бий болгосон.

Өөрөөр хэлбэл, Өршөөл үзүүлэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсгээр хориглоогүй боловч 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж, хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг уг хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу өршөөн хэлтрүүлэх үндэслэлтэй эсэх талаар хууль зүйн маргаан үүсч, хууль хэрэглээний зөрүүтэй байдал үүссэн байна.

Дээр дурдсан нөхцөл байдлыг үндэслэн Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан “Энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 7.1, 7.2, 7.3, 9.1, 9.2-т зааснаас бусад гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн ялтны шүүхээс оногдуулсан, эсхүл эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ” гэдэгт уг хуулийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн үндсэн болон

нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлэхийг багтаан ойлгож хэрэглэх эсэх талаар албан ёсны тайлбар гаргах хэрэгцээ, шаардлага бодитой үүссэн болно.

Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг уг хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу өршөөн хэлтрүүлэх үндэслэлтэй эсэхийг хууль тогтоогчийн санаа зорилго болон системчлэн тайлбарлах аргад тулгуурлан дүгнэлт хийвэл холбогдох хэм хэмжээний агуулгыг тодорхойлох боломжтой юм.

Монгол Улсын Их Хурлаас Өршөөл үзүүлэх тухай хуулийг батлан гаргахдаа хуулийн зорилтыг “Тулгар төр байгуулагдсаны 2230 жил, Их Монгол Улсын 815 жил, Ардын хувьсгалын 100 жилийн ойг тохиолдуулан хүмүүнлэг, энэрэнгүй ёсны зарчмыг удирдлага болгон коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор зарим гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлага, зөрчлийн шийтгэлээс нэг удаа өршөөн хэлтрүүлэх, чөлөөлөх, хасах, ялын төрлийг солихтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн тодорхойлж, улмаар уг хуулийн Хоёрдугаар бүлэгт “Өршөөл үзүүлэх хэлбэр, хүрээ, хэмжээ”-г хуульчлахдаа өршөөлд хамаарах гэмт хэргийг “Энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 7.1, 7.2, 7.3, 9.1, 9.2-т зааснаас бусад гэмт хэрэг” гэж тодотгон заасан нь хуулийг хэлэлцэн батлах үед хууль тогтоогчийн баримталсан хүсэл зориг мөн болох нь хуулийн төслийг хэлэлцсэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэлээр тогтоогдсоноос гадна энэхүү хууль тогтоогчийн үзэл санаа хуулийн төслийн танилцуулга, үзэл баримтлалд тусгагдсан байна.

Тухайлбал, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн барьсан Өршөөл үзүүлэх тухай хуулийн төслийн үзэл баримтлалд “...ФАТФ-ын зөвлөмжийн 3, 5, 35 болон шууд хэрэгжилтийн 7-д нийцүүлэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх, татвар төлөхөөс зайлсхийх, хулгайлах, дээрэмдэх, залилах, хөрөнөг завших, хүрээлэн байгаа орчны эсрэг зэрэг гэмт хэргүүдийг өршөөлд хамааруулахгүй байхаар тусгана” хэмээн заасныг уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 7.1, 7.2, 7.3, 9.1, 9.2-т зааснаас бусад гэмт хэрэг” гэж хуульчилж, өршөөлд хамаарах болон хамаарахгүй гэмт хэргийг ялган тодорхойлжээ.

Харин хууль тогтоогч хууль батлан гаргах үеийн нөхцөл байдал, нийгмийн хэрэгцээ шаардлагыг харгалзан Өршөөл үзүүлэх тухай хуулийн зорилтод “...коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор ... зарим гэмт хэрэг ... үйлдсэн хүний ялыг ... өөр төрлийн ялаар солихтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино” хэмээн тодорхойлсон нь уг хуулийн 7

дугаар зүйл “Хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн солих” гэсэн хэм хэмжээгээр хэлбэржсэн байна.

Өөрөөр хэлбэл, хорих ангид ял эдэлж буй ялтны бөөгнөрлийг сааруулах замаар коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэхийн тулд Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн ялыг бүхэлд нь өршөөн хэлтрүүлэхгүйгээр, зорчих эрхийг хязгаарлах ялаар дүйцүүлэн сольж эдлүүлэхээр зохицуулсан нь тухайн гэмт хэрэгт хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн бусад хүний ялыг Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан журмаар өршөөн хэлтрүүлэх утга санааг агуулаагүй бөгөөд ийм тухайлсан зохицуулалт уг хуульд байхгүй болно.

Эрүүгийн эрх зүйн хууль ёсны зарчмын хувьд авч үзвэл Өршөөл үзүүлэх тухай хуулийн хэм хэмжээний утга санааг агуулгаас нь дэлгэрүүлэн тайлбарлаж, төсөөтэй хэрэглэж болохгүй.

Өршөөл үзүүлэх тухай хуульд хамаарах болон хамаарахгүй гэмт хэргийг 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “энэ хуулийн 6.1, 6.2, 6.3, 7.1, 7.2, 7.3, 9.1, 9.2-т зааснаас бусад гэмт хэрэг” гэж ялган хуульчилсныг уг хуулийн зорилт, хууль тогтоогчийн үзэл баримтлал, хуулийн зохицуулах зүйлийн хэмжээ, хязгаарыг тогтоосон бусад хэм хэмжээтэй харьцуулан системчилж үзэхэд уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг уг хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу өршөөн хэлтрүүлэх агуулгагүй байна.

Иймд Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан “... бусад гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн ялтны шүүхээс оногдуулсан, эсхүл эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ.” гэдэгт уг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2-т заасан гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүн хамаарахгүй гэж ойлгох нь зүйтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4-т заасныг удирдлага болгон Өршөөл үзүүлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан “... бусад гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн ялтны шүүхээс оногдуулсан, эсхүл эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг өршөөн хэлтрүүлнэ” гэснийг

ТАЙЛБАРЛАХ нь:

1.Өршөөл үзүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2-т заасан гэмт хэрэг үйлдэж хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн хүний эдлээгүй үлдсэн үндсэн болон нэмэгдэл ялыг энэ хуулийн 4 дүгээр



зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан журмаар өршөөлд хамааруулахгүй гэж ойлгон хэрэглэнэ.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ШҮҮГЧ**

**Д.ГАНЗОРИГ
Б.БАТЦЭРЭН**

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 02 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 09

Улаанбаатар
хот

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсгийг тайлбарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4 дэх хэсгийг үндэслэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн зарим хэсгийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах нь зүйтэй гэж Монгол Улсын дээд шүүх үзлээ.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсэгт “нэхэмжлэгч нэхэмжлэлээ хариуцагчийн зөвшөөрөлгүй татан авч болно” гэж зохицуулсан бөгөөд уг заалтын “татан авч болно” гэснийг шат шатны шүүхийн практикт хоёр өөр эрх зүйн үр дагавар үүсгэн хэрэглэж байна.

Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсгийн зохицуулалтад албан ёсны тайлбар гаргах хэрэгцээ, шаардлага үүссэн тухай Улсын дээд шүүхийн Иргэний хэргийн танхимаас гаргасан саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр хэлэлцэж, тайлбарын цар хүрээ, тайлбар гаргах арга зүйг зөвшөөрсөн.

1. Албан ёсны тайлбар гаргах зорилгоор хуулийн төсөл хэлэлцсэн болон хууль баталсан хуралдааны тэмдэглэл, төслийн танилцуулга, үзэл баримтлал зэргийг судалж, процессын эрх зүйн зохицуулалтыг уламжлал, шинэчлэлийн хүрээнд авч үзэн, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх 1926, 1956, 1967, 1994, 2002 оны хуулийн хүрээнд түүхчилсэн судалгаа хийлээ.

а/. БНМАУ-ын шүүх таслах газруудад аливаа хэргийг байцаах ба шийтгэх тухай 1926 оны хууль, БНМАУ-ын Иргэний байцаан шийтгэх 1952, 1967 оны хуулиуд, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 1994

оны хуульд “нэхэмжлэгч нэхэмжлэлээ татан авах” талаар зохицуулалт байхгүй байна.

б/. “нэхэмжлэгч нэхэмжлэлээ... татан авч болно...” гэсэн заалт анх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 2002 оны хуульд орсон бөгөөд уг хуульд нэхэмжлэлийг “татан авах” нэр томъёоны тайлбар байхгүйгээс гадна 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсгээс өөр зүйл, заалтад хэрэглэгдээгүй байна.

Хууль батлагдах үеийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, хуулийн төслийг хэлэлцсэн болон баталсан Хууль зүйн байнгын хороо, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны тэмдэглэлд тайлбарлаж буй зохицуулалттай холбоотой мэдээлэл тусгагдаагүй байв.

в/. 2021 оны байдлаар Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 2002 оны хуульд нийт 28 удаа нэмэлт, өөрчлөлт орж 106 дугаар зүйлд зарим зохицуулалтыг өөрчилсөн ч энэ нь тайлбарлаж буй зүйлийн заалтыг хөндөөгүй байна.

2.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэхэмжлэлийг “татан авах” 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсгийн зохицуулалтыг хуулийн зарчим, утга, агуулгын ерөнхий хамааралд нь нийцүүлэн авч үзэв.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай 2002 оны хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсгийн зохицуулалт нь “нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзах” тухай 106.5 болон 74-р зүйлийн зохицуулж буй харилцаатай зарчмын хувьд адил байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсэгт “... нэхэмжлэгч нэхэмжлэлээ... татан авч болно...” гэж, 106.5 дахь хэсэгт “...хуулийн 106.3...-т зааснаар нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан... бол...татгалзлыг... батална.” гэж тус тус зааснаас үзвэл, 106.3 дахь хэсгийн үр дагаврыг 106.5 дахь хэсэг агуулгын хувьд өөртөө багтаажээ.

3.Хуулийн 106.5 дахь хэсэгт зааснаар “...нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан...” тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг хэрхэн хуваарилахыг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5 дахь хэсэгт зохицуулсан бөгөөд энэ тохиолдолд улсын тэмдэгтийн хураамжийг буцаан олгохгүй байхаар заасан байна.

4.Нэгтгэн дүгнэвэл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсгийн “нэхэмжлэгч нэхэмжлэлээ татан авах” гэдгийг 106.5 дахь хэсэгт заасан “нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан”-тай адил утгаар, нэхэмжлэгч субъектив эрхээс татгалзаж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгосон гэж ойлгож хэрэглэхээр байна.



Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсгийн дагуу гарах шүүхийн шийдвэрийн үр дагавар нь мөн хуулийн 106.5 дахь хэсэгт заасантай ижил буюу шүүхэд дахин нэхэмжлэл гаргах эрхгүй гэж үзнэ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4 дэх заалтыг удирдлага болгон **ТАЙЛБАРЛАХ нь:**

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3 дахь хэсгийн “нэхэмжлэгч нэхэмжлэлээ... татан авч болно” гэдгийг мөн хуулийн 106 дугаар зүйлийн 106.5 дахь хэсэгт заасан “нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан”-тай нэгэн адил ойлгоно.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ТАНХИМЫН ТЭРГҮҮН
ШҮҮГЧ**

**Д.ГАНЗОРИГ
Г.АЛТАНЧИМЭГ
Х.ЭРДЭНЭСУВД**

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 дугаар
сарын 09-ний өдөр

Дугаар 11

Улаанбаатар
хот

Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг хэрэглэх талаар албан ёсны тайлбар

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох зохицуулалтыг өөр өөрөөр тайлбарлан хэргийг шийдвэрлэсний улмаас шүүхийн практикт хууль хэрэглээний зөрүү үүссэн нь анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шийдвэрүүдээр тогтоогдож байна.

Тухайлбал, зарим шүүх Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт өөрчлөлт оруулсан 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш хянан хэлэлцэгдэж байгаа хэрэгт хөөн хэлэлцэх хугацааны дотор ял сонсгож, яллагдагчаар татсан бол уг хугацааг цаашид тоолохгүй, зогссонд тооцно гэж үзсэн бол хэд хэдэн шүүх тухайн өөрчлөлт нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан гэж дүгнэн уг заалтын өмнөх агуулгыг буюу гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолж хэргийг шийдвэрлэж иржээ.

Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх тухай албан ёсны тайлбар гаргах хэрэгцээ, шаардлага үүссэн гэж Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимаас шүүхийн шийдвэрүүд, шүүн

таслах ажиллагааны практикт үндэслэн гаргасан саналыг Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдаанаар 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр хэлэлцэж, тайлбарын цар хүрээ, тайлбар гаргах арга зүйг зөвшөөрсөн болно.

2015 оны Эрүүгийн хууль, түүнд өөрчлөлт оруулсан хууль, тэдгээрийн төслийн танилцуулга, үзэл баримтлал, төслийг хэлэлцсэн болон өөрчлөлт оруулсан Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Хууль зүйн байнгын хорооны хуралдааны тэмдэглэл, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 болон 2 дахь хэсэг, мөн 2002 оны Эрүүгийн хуулийн 72 дугаар зүйлийг хэрэглэсэн шүүхийн шийдвэрүүд, тэдгээрт Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгээс хийсэн судалгааны үр дүнг харьцуулан судлахад дараах нөхцөл байдал тогтоогдов.

Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг материаллаг болон процессын хэм хэмжээний алинд нь хамааруулж үзсэнээс шалтгаалж уг заалтын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс өмнөх агуулга “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолно”, эсхүл одоогийн агуулга “Гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолно” гэснийг шүүхүүд өөр өөрөөр тайлбарлан хэрэглэж ирсэн байна.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлд гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааны зохицуулалтыг тусгахдаа 1 дүгээр хэсгийн 1.1-ээс 1.5 дугаар заалт, 6 дугаар хэсэгт гэмт хэргийн ялын хэмжээгээр ангилан мөрдвөл зохих хөөн хэлэлцэх хугацааг тогтоож, 2, 3, 4 дүгээр хэсэгт уг хөөн хэлэлцэх хугацааг тоолоход баримтлах журмыг тусгасан байна. Харин уг зүйлийн 5 дугаар хэсэгт татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэгт хөөн хэлэлцэх тусгай хугацааг зааж өгчээ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйл нь материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээний аль алиныг агуулж байх боловч тус тусын агуулга, зорилгод нийцүүлэн ялгамжтай байдлаар хэрэглэх нь шүүхийн шийдвэр эрх зүйн үндэслэлтэй, хууль ёсны байх шаардлагад нийцнэ. Үүний тулд материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээний мөн чанар, ялгагдах шинжийг объектив телеологийн аргыг сонгож зорилгыг тодорхойлох замаар тайлбарлах нь оновчтой гэж үзэв.

Эрх зүйн хэм хэмжээ нь материаллаг ба процессын хэмээн хуваагдахдаа эхнийх нь нийгмийн харилцаанд оролцох этгээдүүдийг тодорхойлж, тэдний зан үйлийг системчлэн нэгтгэж, улмаар тэдний үйлдэл, эс үйлдэхүй, шийдвэрийн хууль зүйн шинж, үр дагаврыг тодорхойлох замаар эрх, үүргийг үүсгэх, өөрчлөх, дуусгавар болгоход чиглэгддэг бол удаах нь тэдгээр эрх, үүргийг хэрэгжүүлэх, хамгаалах, сэргээх үе шат, дэс дараалал, хугацаа зэргийг тогтоож, хууль зүйн асуудлыг шийдвэрлэх

журмыг бий болгодог ялгаагаараа хэм хэмжээний тогтолцоонд өөр өөр байр суурь эзэлдэг. Энэ утгаараа материаллаг болон процессын хуулиуд нь нэг нэгнээ харилцан нөхөх нэгдмэл шинж чанарыг хадгалахын зэрэгцээ материаллаг хуульд тусгагдсан эрх, үүрэг нь тэдгээрийг хэрэгжүүлэх, хамгаалах, сэргээх журмыг тогтоосон процессын хуульгүй бол нийгмийн харилцаанд үр дагавар, нөлөөлөл үүсгэж чадахгүй.

Эрх зүйн материаллаг хэм хэмжээнүүд нь эрх зүйн институтыг тодорхойлон тэдгээрт хамаарах эрх, үүрэг, хориг, зөвшөөрлийн тогтолцоог бий болгодогтой холбоотой өөртөө тогтоох ба зохицуулах хэм хэмжээг багтаана. Харин процессын хэм хэмжээнүүд нь материаллаг хэм хэмжээнүүдийн хэрэгжих хэлбэр, эрх бүхий этгээдүүдээс уг хэм хэмжээг биелүүлэх, хэрэглэх ажиллагааг журамлаж, материаллаг хэм хэмжээгээр тодорхойлогдсон эрх зүйн дэглэмийг хэрэгжүүлэхийг зорьдог.

Эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний тогтолцоонд материаллаг хэм хэмжээ нь гэмт хэргийн шинж, гэм буруу, тохирох ял, түүнийг хүндрүүлэх, хөнгөрүүлэх нөхцөл байдлуудыг ерөнхий шинжээр тогтоож байхад процессын хэм хэмжээ бодит хэрэг маргаанд тодорхой этгээдийн хувьд тэдгээрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны хэлбэр, дарааллыг тогтоох байдлаар материаллаг хэм хэмжээний үр дагаврыг нөхцөлдүүлдэг. Товчдоо эрүүгийн эрх зүйн материаллаг хэм хэмжээ эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлийг тодорхойлдог бол процессын хэм хэмжээгээр уг үндэслэлийг нотлон тогтоох, тооцон хэрэгжүүлэх аргачлалыг заана гэж ойлгож болно.

Материаллаг болон процессын эрх зүйн хэм хэмжээг дээрх шалгууруудаар нягтлан ялгахад Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1.10 дугаар зүйлд тодорхой төрлийн гэмт хэргүүдэд хөөн хэлэлцэх хугацаа тогтоосон материаллаг шинжтэй зохицуулалтуудаас гадна уг хугацааг хэрхэн тоолж, тооцох тухай процессын шинжтэй зохицуулалтууд холилдож тусгагджээ.

Хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, тоолох асуудлыг зохицуулсан материаллаг болон процессын хэм хэмжээ нь шинж чанараараа ялгаатай болохыг эрх зүй судлаачид, хуульчид нийтээр хүлээн зөвшөөрдөг боловч харилцан уялдах, бие биенээ нөхөх шинж чанарыг харгалзан хууль тогтоогч нэг хуульд багтааж тусгах явдал түгээмэл байна. Энэ нь хууль тогтоомжийг боловсронгуй болгох зорилгыг эрх зүйн эх сурвалжийг эмхлэх, цэгцлэх, хэм хэмжээний дотоод зөрчил, хийдлийг арилгах замаар хангахыг чухалчилж, хууль зүйн техникийн эрх зүйг системчлэх хэлбэрийг илүү баримталдагтай холбоотой.

Тухайлбал, хөөн хэлэлцэх хугацааг тоолох, хорих ялаас хугацаанаас өмнө суллан хянах, хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн хүнд ялыг нэгтгэн оногдуулах, хэд хэдэн шийтгэх тогтоолоор оногдуулсан ялыг нэгтгэх, өсвөр насны этгээдэд ял оногдуулах болон өвчний учир ялаас

чөлөөлөх зэрэг завсрын процесс гэж нэрлэгдэх, гэм буруутай эсэхийг тогтооход чиглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх үндсэн ажиллагаанд хамааралгүй атлаа түүний явцад гарсан эрх зүйн асуудлыг зайлшгүй тусад нь шийдвэрлэх үйл явцыг журамласан дүрмийг ихэнх тохиолдолд материаллаг зохицуулалттай хамт Эрүүгийн хуульд хуульчилдаг нь хууль тогтоогч хууль тогтоомжийн нэгдсэн системчлэлд түлхүү анхаардгийн илэрхийлэл юм.

Үүний нэгэн адил нотолбол зохих байдлууд, нотолгооны хэр хэмжээ, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч, оролцогч нарын эрх, үүрэг зэрэг олон материаллаг зохицуулалтыг тухайн этгээдүүдийн зүгээс хэрэгжүүлэх үйл ажиллагааны журамд багтаан Эрүүгийн процессын хуульд хамтатган тусгадаг нь эх газрын эрх зүйн бүлд багтах улсуудын хууль тогтоох байгууллагын практикт түгээмэл хэрэгжүүлдэг туршлага.

Эрүүгийн эрх зүйн аливаа хэм хэмжээг аль хуульд тусгагдсан байдлаар шалгуур болгож материаллаг эсхүл процессын хэм хэмжээнд хамааруулж дүгнэлт хийх нь цаашид хууль хэрэглээний алдаатай шийдвэр гаргах эрсдэл дагуулна.

Иймээс шүүх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тогтоох, тоолох зохицуулалтыг хэрэг маргаанд хэрэглэхдээ материаллаг эсвэл процессын хуульд тусгагдсанаар бус зохицуулж байгаа харилцааны мөн чанар, агуулга, зорилгод ач холбогдол өгч, эрх, үүргийг бий болгож байгаа эсвэл эрх, үүргийг хэрэгжүүлэх арга замыг тодорхойлж байгаагаар нь ялган дүгнэлт хийх шаардлагатай.

Материаллаг болон процессын хэм хэмжээ хэд хэдэн шинж чанараар ялгагддагаас тэдгээрийн цаг хугацааны мөчлөгт орших байршлын онцлог нь хөндөгдөж буй асуудалд чухал ач холбогдолтой байна. Тухайлбал, хууль түүнийг батлагдахаас өмнө бий болсон үйл баримтад буцаж үйлчлэхгүй тухай *lex retro non agit¹*, *nullum crimen, nulla poena sine lege²*, *lex severior poenali retro non agit³* зарчмуудад процессын хэм хэмжээ захирагдаж байхад материаллаг хэм хэмжээ нь *lex mitior poenali retro agit⁴* буюу товчоор *lex mitior⁵* зарчмын үр дүнд цаг хугацаанд шилжилт хийх боломжтой байна.

Ийнхүү процессын хэм хэмжээ нь эрх зүйн хэм хэмжээний бүхий л ерөнхий шинж чанаруудыг өөртөө агуулж хүчин төгөлдөр үйлчилсэн цаг хугацаатайгаа хөдөлгөөнгүй уягддаг бол эрүүгийн эрх зүйн материаллаг хэм хэмжээ нь хэргийн үйл баримтаас хожим үйлчилж эхэлсэн ч шүүгдэгчийн

¹ Ямар ч хууль буцаж үйлчлэхгүй лат.

² Хууль үгүй бол гэмт хэрэг үгүй лат.

³ Хүндрүүлсэн Эрүүгийн хууль буцаж үйлчлэхгүй.

⁴ Зөвхөн хөнгөрүүлсэн Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэнэ.

⁵ Илүү хөнгөн лат.



хувьд *in mitius*⁶ байдлаар буцаан хэрэглэгдэх боломжтой. Буцаан хэрэглэх боломжтой хуулиудыг ерөнхийд нь *ex post facto*⁷ ангилалд хамааруулдаг бол аливаа процессын шинжтэй хэм хэмжээ мөн чанараасаа шалтгаалан энэ ангилалд багтдаггүй.

Эдгээр зарчмууд Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "... үйлдэх үед нь үндэсний хууль буюу олон улсын эрх зүйгээр эрүүгийн гэмт хэрэгт тооцогдож байгаагүй ямар нэг үйлдэл буюу эс үйлдэлд хэнийг ч гэм буруутайд тооцож болохгүй. Түүнчлэн гэмт хэрэг үйлдэх үед хэрэглэж байснаас илүү хүнд ял шийтгэл оногдуулж болохгүй. Гэмт хэрэг үйлдэгдсэнээс хойш уг хэргийн ялыг хуулиар хөнгөлсөн бол уг яллагдагчид тэрхүү хөнгөлсөн ялыг хэрэглэнэ." гэж тодорхой туссан байна. Уг заалтад дурдагдсан гэмт үйлдэл, эс үйлдэхүйн шинж, оногдуулах ял шийтгэл, хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг тогтооход чиглэсэн зохицуулалтууд нь эрүүгийн эрх зүйн материаллаг хэм хэмжээнд хамаарах нь маргаангүй ба энэ шинж чанараараа хөнгөрүүлсэн шинэ хэм хэмжээ гарсан бол *ex post facto* зарчмаар өмнөх үйл баримтад буцаж хэрэглэгдэх боломжтой.

Эрүүгийн хуульд тусгагдсан материаллаг хэм хэмжээ нь *lex severior poenali*⁸ үед буцаж үйлчлэх байдлаар өнгөрсөн ба эдүгээ цагт зэрэг хүчин төгөлдөр байж чадах бол процессын хэм хэмжээний хувьд бүх тохиолдолд *lex retro non agit* зарчмын нөлөөллөөр зөвхөн одоо үйлчилж буй хэм хэмжээ нь мөрдөгдөж өмнөх зохицуулалт халагддаг.

Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн 22 дугаар зүйлийн 2, 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгүүдэд *nullum crimen sine lege, lex retro non agit ratione personae* болон мөн *lex mitior* зарчмуудын үйлчлэлээр шүүгдэгчид ашигтай хуулийг хэрэглэх тохиолдлыг зөвхөн гэмт хэргийн шинж бүрэлдэхүүн, гэмт үйлдэл, эс үйлдэхүйн материаллаг тодорхойлолттой холбогдуулан зөвшөөрч, харин 29 дүгээр зүйлд хөөн хэлэлцэх хугацааг Олон улсын Эрүүгийн шүүхийн харьяаллын хэргүүдэд хэрэглэхгүй байхаар заасан байна.

Ромын дүрмийн 51 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт хэргийг нотлох болон хянан хэлэлцэх ажиллагааны журамд хожим орсон өөрчлөлтийг шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах байдлаар буцаан хэрэглэхийг хориглосон нь *lex severior poenali retro non agit* зарчмын тусгал бөгөөд шүүгдэгчийн хувьд өмнөх процессын хуулийн үйлчлэлээр үүсэж, хэрэгжсэн эрхийн улмаас бий болсон үр дагаврыг шинэ процессын хуулиар өөрчилж, хүчингүй болгохыг хориглосон агуулгатай. Энэ нь процессын хэм хэмжээг буцааж хэрэглэхгүй тухай ерөнхий зарчмын тусгай тохиолдлыг илэрхийлнэ.

⁶ Ашигтайгаар лат.

⁷ Өмнөх үйл баримтад хууль хэрэглэгдэх буюу хууль буцаж үйлчлэх лат.

⁸ Илүү хүнд ял тусгасан лат.

Тодорхой харилцаанд нэг нэгнээ халж шинэчлэх байдлаар дараалж зохицуулсан процессын хэм хэмжээнүүд нь үйлчилсэн тус тусын цаг хугацааны тооллоор хэмжигдэж, үйлчлэл нь эхэлж бас төгсөж, цаг хугацааны шугамд тасралтгүй, залгамжтайгаар давхцаж зэрэгцэхгүйгээр орших нь процессын шинжтэй хэм хэмжээг илэрхийлэх харьцангуй тогтвортой шинж чанар мөн.

Энэ шинж чанар нь процессын хэм хэмжээ зохистой, үр дүнтэй, урьдчилан төсөөлөгдөх, тогтвортой байдлаар үйлчлэх баталгаа болно. Хэрэв процессын хэм хэмжээг хэрэг маргаанд материаллаг хэм хэмжээний адил зарчмаар хэрэглэвэл хууль урьдчилан тодорхой байх, тогтвортой бөгөөд бүгдэд тэгш үйлчлэх зарчмууд зөрчигдөж тухайн процессын хэм хэмжээгээр зорьсон үр дүн бий болохгүй.

Материаллаг хэм хэмжээ нь зорилгыг тодорхойлж, процессын хэм хэмжээ тухайн зорилгод чиглэсэн үйл ажиллагааг хөтлөх нарийвчилсан зааварчилгааг бий болгож, зорилго биелэх баталгааг бүрдүүлдэг тул эдгээрийн байрыг сольсноор энэ баталгаа алдагдах магадлал бодитой болох юм. “*Due process*” буюу зайлшгүй хийгдэх процесс гэх ойлголтын суурь үзэл баримтлал ч үндэс тулгуурласан.

Дээрх зарчмуудыг эрүүгийн эрх зүйн хэм хэмжээнд хамаатуулан тусгавал нэг цаг хугацааны мөчлөгт эрүүгийн процессын хоёр журам зэрэг үйлчлэх боломжгүй гэж дүгнэж болно. Эрүүгийн эрх зүйн материаллаг хэм хэмжээний үйлчлэл юуг гэмт хэрэгт тооцох, ямар шинж бүрдэлтэй байх, тэдгээрт ногдуулах ялын төрөл, хэмжээ зэрэгт төвлөрдгөөс гэмт хэрэг үйлдэгдсэн цаг хугацаатай, харин процессын хэм хэмжээ хэргийг хянан шийдвэрлэхэд чиглэдгээс хэргийг хэлэлцэж буй цаг хугацаатай тус тус уялдах тул материаллаг хэм хэмжээний хувьд гэмт хэрэг үйлдэгдсэн буюу өнгөрсөн цагт үйлчилж байсан зохицуулалтыг, харин процесс дээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж буй одоо цагт мөрдөгдөж байгаа зохицуулалтыг тус тус хэрэглэнэ. Хэрэг үйлдэгдсэн цаг хугацааг процессын журмыг сонгох, өөрчлөх шалгуур болгон хэрэглэж болохгүй.

Эдгээр зарчмууд нь хөөн хэлэлцэх хугацааг тогтоох болон тоолох зохицуулалтууд хэдийгээр хоёул Эрүүгийн хуульд тусгагдсан боловч хөөн хэлэлцэх хугацааг тогтоож болон тоолж буй шинжээрээ эхнийх нь материаллаг эрх зүйн, удаах нь процессын эрх зүйн хэм хэмжээний шинж чанарыг агуулсан гэж дүгнэх онолын үндэслэл болно.

Хөөн хэлэлцэх хугацааг тогтоох болон тоолох нь харилцан нөхөх, нэгдмэл шинж чанартай харилцаа болохын хувьд нэг хуулиар зохицуулж, мөн нягт уялдуулан хэрэглэсний үр дүнд Эрүүгийн хуулиас гадна Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн зорилт, зарчмуудыг хамтад нь хангах боломж бүрддэг.



Нөгөө талаас тэдгээрийн тодорхой хэрэг маргааныг шийдвэрлэхэд гүйцэтгэх үүрэг, зорилгын ялгааг үгүйсгэн адил арга зүйгээр хэрэглэвэл цаг хугацааны мөчлөгт мөрдөгдөх хэм хэмжээний эрэмбэ алдагдан, зохицуулалтын давхцал, зөрчилдөөнийг бий болгодгийг шүүхийн практик өөрөө тодорхой харуулсан. Ийм үр дагавар бий болгохгүйн тулд эрх зүйн материаллаг болон процессын хэм хэмжээний зорилго, мөн чанарын ялгаатай байдлыг тооцсон хууль хэрэглээний нэгдмэл практикийг бий болгох шаардлагатай.

Иймээс эрүүгийн хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох зохицуулалтын хэрэглээ нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт тусгагдсан “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахдаа хүчин төгөлдөр үйлчилж байгаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг баримтална” гэсэн нийтээр хүлээн зөвшөөрсөн эрх зүйн зарчмаар хязгаарлагдах ёстой.

Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн өөрчлөлтөөс өмнөх болон дараах агуулгын аль алин нь процессын шинжтэй, сүүлийнх нь хуучнаа халж шинэчилсэн заалт тул процессын хэм хэмжээний мөн чанарын дагуу цаг хугацааны шугамд үйлчлэлээрээ давхцахгүйгээр дараалж байршин хэрэг маргаан хянагдаж буй цаг хугацааг өөртөө багтаах мөчлөгт зөвхөн шинэчлэгдсэн нэг зохицуулалт нь хэрэглэгдэнэ. 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хууль хүчин төгөлдөр болсноор зохицуулалтын давхцлыг заагласан гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, энэ цаг хугацаанаас хойш хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт болон шүүхийн шатанд хянагдаж буй хэргийг шийдвэрлэхдээ уг заалтын өмнөх агуулга “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэл тоолох” зохицуулалтыг баримтлахгүй, харин түүний зөвхөн шинэ агуулга “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолох” зохицуулалтыг хэрэглэнэ.

Нэгтгээд дүгнэвэл, хууль тогтоогч гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг өөрчилснөөр Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааны дотор тухайн этгээдийг яллагдагчаар татсан бол хөөн хэлэлцэх хугацаа зогсох ба энэхүү процессын хэм хэмжээний мөн чанарыг агуулсан зохицуулалт нь хүчин төгөлдөр болж мөрдөгдөж эхэлснээсээ хойш үйлчлэх бөгөөд уг заалт өөрчлөгдөхөөс өмнө мөрдөж байсан зохицуулалтыг буцааж хэрэглэхгүй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулийн тухай 1.15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан “...хуулийг тайлбарлах, хэрэглэхэд гарсан эргэлзээг яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх” зарчим нь процессын хэм хэмжээний тухайд хэрэг хянагдаж буй цаг хугацаанд мөрдөгдөж байгаа хуулийн заалтыг тайлбарлахад хамааралтай бөгөөд



Эрүүгийн болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиуд дахь процессын шинэчлэгдсэн зохицуулалтыг өмнөхтэй нь өрсөлдүүлэн хэрэглэх тухай ойлголтыг агуулаагүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4 дэх заалтыг удирдлага болгон

ТАЙЛБАРЛАХ нь:

1. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт өөрчлөлт оруулсан 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, прокурорын хяналт болон шүүхийн шатанд хянагдаж буй хэрэгт “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг гэмт хэрэг үйлдсэн өдрөөс эхлэн яллагдагчаар татах хүртэл тоолох” зохицуулалтыг хэрэглэнэ.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**Д.ГАНЗОРИГ
Ч.ХОСБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 03 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 13

Улаанбаатар
хот

Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтын албан ёсны тайлбар

Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтад албан ёсны тайлбар хийх хэрэгцээ, шаардлага үүссэн, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах зорилгоор шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Захиргааны хэргийн танхимаас гаргасан саналыг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар 2021 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр хэлэлцэж, тайлбар гаргах арга зүйг зөвшөөрсөн.

Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулиар Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйл дэх ашигт малтмалын асуудлаарх Засгийн газрын бүрэн эрхэд шинээр 9.1.9-9.1.13 дугаар заалтууд нэмсэн, үүнд 9.1.13-т “ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх томоохон хэмжээний төслийг хэрэгжүүлэх, тусгай хэрэгцээнд авах зорилгоор төрийн мэдэлд шилжүүлэн авч нөхөх олговрын асуудлыг шийдвэрлэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хэлэлцэн тохирсоны үндсэн дээр энэ хуулийн



19.12, 26.9-д заасан талбайгаас тусгай зөвшөөрөл олгож болно” гэж заасан, уг заалтын “энэ хуулийн 19.12” гэснийг “улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын явцад тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий талбай болон энэ хуулийн” гэж 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар өөрчилсөн; 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн хуулийг мөн өдрөөс дагаж мөрдөх ба буцаан хэрэглэхгүй гэж, 2017 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулийг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр үйлчилж эхлэх хугацаа, хэрэглэх журмыг тус тус тухайлан тогтоожээ.

Уг хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтын агуулга нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг төрийн мэдэлд тодорхой зорилгоор шилжүүлэн авахдаа тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговрыг олгоно, хэрэв хэлэлцэн тохирсон бол “өөр талбай”-д ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгож болох Засгийн газрын бүрэн эрхийг баталгаажуулсан байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 8 дугаар зүйлд ашигт малтмалын асуудлаарх Улсын Их Хурлын бүрэн эрхийг тодорхойлсон, үүний 8.1.5-д “Засгийн газрын өргөн мэдүүлснээр, эсхүл өөрийн санаачлагаар тодорхой нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг, эсхүл хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хязгаарлах буюу хориглох” хууль батлах бүрэн эрхтэй, энэ хүрээнд Улсын Их Хурлаас тодорхой цаг хугацаагаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл шинээр олгохыг, мөн нутаг дэвсгэрийн тодорхой газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох хуулиудыг батлан гаргасан, тэдгээрийн нэг нь 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр баталсан Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль юм.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д “Ашигт малтмалын тухай хуулийн 56.1.3-т заасны дагуу тусгай зөвшөөрлийг цуцлахдаа уг тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор төлөх бөгөөд холбогдох журмыг Засгийн газар тогтооно” гэж заасны дагуу нөхөх олговор олгосны үндсэн дээр тусгай зөвшөөрлийг цуцлах бөгөөд нөхөх олговрын харилцааг Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 299 дүгээр тогтоолоор баталсан “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор олгох журам”-аар тусгайлан зохицуулсан.

Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн үйлчлэлд хамаарсан бөгөөд Засгийн газраас



тогтоосон “журам”-ын дагуу олгогдвол зохих “нөхөх олговор”-ыг төрөөс олгоогүй гэх шалтгаанаар тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан этгээдээс Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13-т заасан “нөхөх олговор”-ыг буюу “талбай авах” хүсэлтийг ашигт малтмалын асуудлаарх төрийн захиргааны байгууллагад гаргаж, улмаар татгалзсан хариу авснаар уг шийдвэрийг эс зөвшөөрсөн эсхүл хүсэлтийг нь шийдвэрлээгүй гэх үндэслэлээр захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан; Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн үйлчлэлд хамаарсан хэдий ч дээрх “журам”-д заасны дагуу нөхөх олговор авах хүсэлт гаргаж байгаагүй тусгай зөвшөөрөл эзэмшигчээс гаргасан “... хуулийн улмаас зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах боломжгүй байсан эрх зүйн харилцааг тогтоолгох, нөхөх олговорт “талбай дүйцүүлэн олгох”-ыг даалгуулах, эдгээрт холбогдох хүсэлтийг нь ашигт малтмалын асуудлаарх төрийн захиргааны байгууллага шийдвэрлээгүй” гэх үндэслэлээр маргасан, шүүх энэ төрлийн маргааныг хянан шийдвэрлэхдээ Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтыг өөр өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн нь анхан, давах, хяналтын шатны шүүхийн дараах шийдвэрүүдээр илэрч байна.

1. Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2018 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 143 дугаар тогтоолоор “Ө Т” ХХК-ийн нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээсэн бол 2018 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 199 дүгээр тогтоолоор “Ч м д” ХХК-ийн нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээсэн; 2019 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 231 дүгээр тогтоолоор “М” ХХК-ийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалыг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

2. Хяналтын журмаар гомдол гаргаагүй, хуулийн хүчин төгөлдөр болсон Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 101 дүгээр магадлалаар “Б А И” ХХК-ийн Засгийн газарт холбогдуулан гаргасан нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгосон анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээсэн бол 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 162 дугаар магадлалаар “С з” ХХК-ийн нэхэмжлэлийг хангаж шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээжээ.

3. Давж заалдах журмаар гомдол гаргаагүй, хуулийн хүчин төгөлдөр болсон нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 261 дүгээр шийдвэрээр “Ч” ХХК-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хангаж, ...15,768.58 гектар талбайд дүйцүүлэн

нэхэмжлэлд дурдсан солбицлын дагуу нөхөх олговрын зориулалтаар шинээр хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хариуцагч Ашигт малтмал, газрын тосны газарт даалгаж; 2019 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 905 дугаар шийдвэрээр “Б” ХХК-ийн “...нөхөх олговорт талбай дүйцүүлэн олгох шийдвэрийг Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.13, 11.1.19-д заасны дагуу гаргахгүй байгаа Ашигт малтмал, газрын тосны газрын эс үйлдэхүй хууль бус болохыг тогтоож, шийдвэр гаргахыг даалгаж” тус тус шийдвэрлэжээ.

Дээрх байдлаар, “Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль”-ийн үйлчлэлд хамаарсан бөгөөд уг хуулийн дагуу “нөхөх олговор”-ын харилцаанаас үүссэн маргаанд “Ашигт малтмалын тухай хууль”-ийн 9 дүгээр зүйлийн 9.1.13-т заасан буюу өөр зорилго бүхий харилцаанаас үүсэх “нөхөх олговор”-ын зохицуулалтыг “хэрэглэх боломжтой” эсхүл “хэрэглэх боломжгүй” гэж өөр өөрөөр тайлбарлан хэрэглэсэн нь шүүхийн практикт хууль хэрэглээний зөрүү үүсгэсэн байна.

Аль аль хуульд тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хохирлыг барагдуулах зорилготой “нөхөх олговор”-ын харилцааг өөр өөр нөхцөл, болзолтойгоор ялгаатай хуульчилсан, хууль хэрэглэх дарааллын зарчмын үүднээс тухайлсан харилцаанд хамааралтай хэм хэмжээг ерөнхий зохицуулалттай хуулиас түрүүлж хэрэглэнэ, тусгайлсан хуульд маргаантай харилцааг зохицуулсан хэм хэмжээ агуулагдаагүй бол ерөнхий зохицуулалттай хуулийн хэм хэмжээг хэрэглэж шүүх хэргийг шийдвэрлэх зарчимтай.

Түүнчлэн, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулиар зохицуулсан “нөхөх олговор” нь мөнгөн хэлбэрээр илэрхийлэгдэх бөгөөд уг хууль батлагдсантай холбогдуулан Ашигт малтмалын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.3-т заасан тусгай зөвшөөрөл цуцлагдах үндэслэлд “...эсхүл тухайн талбайд ашигт малтмал хайх, ашиглахыг хуулиар хориглож нөхөх олговрыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүрэн төлсөн” гэсэн хэсгийг 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн хуулиар нэмжээ.

Улсын Их Хурал 2009 оны 07 дугаар сарын 16-ны өдөр баталсан Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх ашиглахыг хориглох тухай хуулийн үйлчлэлд хамаарч, тусгай зөвшөөрөл нь цуцлагдах тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөх олговор олгох асуудлыг уг хуулийн 4 дүгээр зүйлийн 4.6-д заасны дагуу Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 299 дүгээр тогтоолоор баталсан “журам”-аар тухайлан зохицуулсан уг харилцаанд Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтыг хэрэглэхгүй, энэ хуулийг Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан

бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх ашиглахыг хориглох тухай хуулийн харилцаанаас үүссэн маргаанд төсөөтэй хэрэглэх хууль зүйн боломжгүй юм.

Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүхүүд өөр өөрөөр тайлбарлаж хэрэглэсэн хууль хэрэглээний зөрүүг арилгах, хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах нь зүйтэй гэж нийт шүүгчийн хуралдаанаас үзэв.

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.4-т заасныг удирдлага болгон Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтыг

ТАЙЛБАРЛАХ нь:

1.Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайг үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх томоохон хэмжээний төсөл хэрэгжүүлэх, тусгай хэрэгцээнд авах зорилгоор төрийн мэдэлд шилжүүлэн авах талаар Улсын Их Хурал болон Засгийн газраас хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд гаргасан шийдвэр нь уг шийдвэрийн улмаас тусгай зөвшөөрөл эзэмшигчид үүссэн үр дагаврыг Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13 дахь заалтын дагуу нөхөх олговрын журмаар шийдвэрлэх, ингэхдээ харилцан тохиролцсон бол “өөр талбай”-г дүйцүүлэн олгох үндэслэл болно.

Энэ заалтын “үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх томоохон хэмжээний төсөл хэрэгжүүлэх” гэдэгт уг зорилго бүхий тодорхой тохиолдол бүрээр гаргах хуулиар олгогдсон Улсын Их Хурлын болон Засгийн газрын бүрэн эрхэд хамааралтай үйл ажиллагааг хамааруулан ойлгоно.

Энэ заалтын “тусгай хэрэгцээнд авах” гэдгийг Газрын тухай хуульд заасан газрын нэгдмэл сангийн ангиллын газрыг Улсын Их Хурал болон Засгийн газраас уг хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд улсын тусгай хэрэгцээнд авч, тухайн газарт ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглох үйл ажиллагааг ойлгоно.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг Газрын тухай хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд, хуульд заасан зориулалтаар аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тохиолдлыг энэ заалтын “тусгай хэрэгцээнд авах” гэдэгт хамааруулан ойлгохгүй.

Энэ заалтын нөхөх олговрын журмаар олгох талбай нь тухайн талбайг нөхөх олговрын журмаар олгох талаар тусгай зөвшөөрөл эзэмшигч болон Засгийн газар, эсхүл түүний эрх олгосны дагуу ашигт малтмалын

асуудлаарх төрийн захиргааны төв байгууллага болон төрийн захиргааны байгууллага нь харилцан зөвшилцөлд хүрсэн байх, үүний үндсэн дээр шинээр олгогдох уг талбайн хил зааг, солбицол, хэмжээ, байрших газар нутгийн нэр зэргийг тодорхойлсон Засгийн газрын шийдвэр гарсан байх бөгөөд тухайн талбай нь улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэсэн геологийн судалгааны ажлын явцад тогтоогдсон эрдсийн хуримтлалтай, эсхүл улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нөөц нь тогтоогдсон талбай байна.

2.Энэ заалтын “тусгай зөвшөөрөл олгож болно” гэснийг нөхөх олговрын зориулалтаар талбай олгох эсэх нь Захиргааны ерөнхий хуулийн 42 дугаар зүйлд заасан “сонгох боломж” бөгөөд Засгийн газар өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргах эрхтэй, Засгийн газраас шийдвэр гаргасан тохиолдолд тухайн шийдвэрийг үндэслэн геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын геологийн асуудал эрхэлсэн нэгжийн даргын шийдвэрээр ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шинээр олгохыг ойлгоно.

3.Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13-т “ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгосон талбайг тусгай хэрэгцээнд авах”, 14 дүгээр зүйлийн 14.1, 14.4-т “хүчин төгөлдөр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн тусгай хэрэгцээнд авах” талаар эрх бүхий этгээдээс шийдвэр гаргах боломжийг хуульчилсан, аль ч тохиолдолд хүчин төгөлдөр ашигт малтмалын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг улсын тусгай хэрэгцээнд авсны улмаас тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглах боломжгүй болсон бол тусгай зөвшөөрөл эзэмшигч хуульд тухайлан заасан үндэслэл, журмын дагуу нөхөх олговор шаардах эрхтэй.

Хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг Ашигт малтмалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.13-т заасан үндэслэлээр улсын тусгай хэрэгцээнд авсан бөгөөд нөхөх олговорт энэ зүйлд заасан талбай олгох талаар Засгийн газрын шийдвэр гараагүй тохиолдолд тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хуульд заасан үндэслэл журмын дагуу нөхөх олговрыг мөнгөн дүнгээр тооцуулах хэлбэрээр авах боломжийг өөрт хадгалагдсан гэж ойлгоно.

**ЕРӨНХИЙ ШҮҮГЧ
ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**Д.ГАНЗОРИГ
Ч.ТУНГАЛАГ**

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 4.25

Индекс: 200003